# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2026 оны 03 сарын 11 -ны өдөр Дугаар БА-079/2026 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 2 давхар 1 блок бүхий хүчин чадалтай Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/861 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2022.05.19 огноо, 0010912 313/2022 дугаар;

2.2.Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар УЗ-06/2022;

2.3.Захиалагч: Глобал Сивик Шэйринг ТГ оноосон нэр, 9093907 регистрийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Рашаант, Ухны ам, 90116046 холбоо барих утас, gcsmongol@gcs.or.kr цахим хаяг;

2.4.Барилгын ажлын гүйцэтгэгч: Роуд Девелопмент ХХК оноосон нэр, 9011370047 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5185718 регистрийн дугаар, БУ18-671/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, 120 мянгат, 10 дугаар байр, 2 тоот, 88114525 холбоо барих утас, road2007b@gmail.com цахим хаяг;

2.5.Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6.Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Уран үзэг ХХК оноосон нэр, 9011406050 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5697484 регистрийн дугаар, ЗТ16-36/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9 дүгээр хороо, Шар хад 30, 474 тоот, 99719545 холбоо барих утас, uranuzeg@gmail.com цахим хаяг;

2.7.Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Глобал Сивик Шэйринг ТГ оноосон нэр, 9093907 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Рашаант, Ухны ам, 90116046 холбоо барих утас, gcsmongol@gcs.or.kr цахим хаяг;

2.8.Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

ЛТ ШАЛ
ГАЗА
Барилга байгууламж
оруулах к

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1.Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 2 давхар 1 блок бүхий хүчин чадалтай Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а).барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б).барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3.Ашиглагч байгууллагад:

а).барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б).барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в).барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4.Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1.Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 2 давхар 1 блок бүхий хүчин чадалтай Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо,
Глобал Сивик Шэйринг ТГ-ын захиалгатай, зоорьгүй 2 давхар 1 блок
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газар,
Барилга байгууламжийн
ашиглалт, бүртгэлийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Глобал Сивик Шэйринг
ТГ-ын захирал (Н.Батдорж)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объект № 1068
Огноо 2026 оны 03 сар 11 өдөр
Бүртгэсэн: О. Мөнх
УЛААНБААТАР ХОТ ТТИ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 21 ДҮГЭЭР ХОРОО, ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ ТГ-ЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 2 ДАВХАР 1 БЛОК ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОРЫН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 16 — Улаанбаатар хот

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Глобал Сивик Шэйринг ТГ-ын захиалгатай зоорьгүй 2 давхар 1 блок Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын хурал 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 11 цагт тус газарт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13 цагт дуусав.

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1. | Комиссын дарга: Хотын стандарт, хяналтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. | Хотын стандарт, хяналтын газар, барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 3. | Нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын Улсын ахлах байцаагч | П.Даваатөмөр |
| 4. | Төмөр замын эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр анги, Мандал өртөө, Инженер | А.Анхбаяр |
| 5. | Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, мэргэжилтэн | Н.Даваадэмид |
| 6. | Хот байгуулалт, хөгжлийн газар, Мэргэжилтэн | Б.Анхтөр |
| 7. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Газар ашиглалт, барилга байгууламжийн хяналт хариуцсан мэргэжилтэн | Д.Сугар |
| 8. | Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч | Ж.Хүдэрчулуун |
| 9. | Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 10. | Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 11. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага | Б.Болормаа |
| 12. | Ашиглалт хариуцах байгууллага “Глобал Сивик Шэйринг” ТГ-ын захирал | Н.Батдорж |
| 13. | Зураг төсөл зохиогч байгууллага “Уран Үзэг” ХХК-ний захирал, архитектор | Ө.Эрдэнэгэрэл |
| 14 | Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага “Роуд Девелопмент” ХХК-ний захирал | М.Батсайхан |

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Глобал Сивик Шэйринг ТГ-ын захиалгатай зоорьгүй 2 давхар 1 блок Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилга угсралтын гүйцэтгэлийг хянаж дараах саналуудыг гаргав.

Хотын стандарт, хяналтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал**

- БНТД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих;
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх;
- Батлагдсан ЕТ-ын дагуу гадна тохижилтыг хийж хэрэгжүүлэх;
- Шалнаас тааз хүртэлх цонхонд металл хамгаалалт хийх;
- Дээврийн усны хаялгыг доош буулгах;
- Цахилгааны холбогдох шийдвэрүүдийг албажуулах;
- Дотор хялгасан болон хэвтээ хагарлуудад зохиогч, гүйцэтгэгч, ашиглагч нар тайлбар албан тоот ирүүлэх;
- 1, 2-р давхарын тааз, шалгүй хонгил (цоожтой хаалга) тайлбар ирүүлэх (зохиогч, гүйцэтгэгч, ашиглагч);

ХЯНАЛТ
Барилга байгу
ор

Хотын стандарт, хяналтын газар, барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ж.Жүгдэрмаа**

- Дээврийн ус зайлуулах хоолойг гүйцээх, хучлагын өөрчлөлтийн гүйцэтгэлийн зураг төслийг хянуулж зохиогчийн дүгнэлтэд тусгаж, захиалагчаас ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах талаар тайлбар баталгаа ирүүлэх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай;

Нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч **П.Даваатөмөр**

- Гүний худгийн орчмын хог хаягдлыг цэвэрлэх, худгийн доторх хог хаягдлыг цэвэрлэж зургаар ирүүлэх;

- Гүний худгийн зөвшөөрөл НБОГ-аас авах (ирүүлэх)
- Ундны усны хими, нян судлал, хүнд металлын шинжилгээг хийлгүүлж дүгнэлт гаргуулах (хугацаа алдалгүй);
- Агуулах, гал тогоонд 1 байна. хуурай хүнс, ногоо хадгалах агуулахыг тусад нь шийдэж, тавиуртай болгож зургаар ирүүлэх;
- Гал тогооны өрөөнд тос баригч суурилуулах;
- Бохир усыг зайлуулах талаар цэвэрлэгээний технологи бичиж ирүүлэх, лаг болон цэвэрлэсэн бохир усыг халдваргүйжүүлэх, ашиглалтын явцад хэвийн үйл ажиллагааг хангах баталгааг албан бичгээр ирүүлэх, мэргэжлийн хүмүүс ажиллуулах;
- Цэвэр усны нөөцийн савыг угааж халдваргүйжүүлсэн акт ирүүлэх
- Ариун цэврийн өрөөнүүдийн үнэр гаргагч, зайлуулагч гаргах;

Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр анги, Мандал өртөө, Инженр **А.Анхбаяр**

- Цахилгааны ерөнхий шитэнд ерөнхий газардуулга хийх, туршуулах;
- Гал тогооны өрөөнд байгаа цахилгааны шитний кабель ил холбогдсон байгаад хамгаалалт хийх;
- Цахилгааны шитнээс гарсан утас шитний их биед хүрсэн тул хамгаалалт хийх;
- Бойлерийн өрөөнд цахилгааны розетка ус чийгний хамгаалалтгүй тул ус чийгний хамгаалалттай розеткаар солих;
- Цахилгааны шитэнд давхарлаж холбосон нойлын утаснуудыг салгаж холбох;
- Амрах байранд оронд байрлуулсан розеткийг салгах;

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, мэргэжилтэн **Н.Даваадэмид**

- Мобинет төв шилэн кабелийг салаалан авсан газраас өөрийн сургалтын төв хүртэлх газраар татсан шилэн кабелийн трассыг мэдээллийн санд оруулан гүйцэтгэгч компаниас авах (комиссын үйл ажиллагаанд бэлэн байлгах)

Хот байгуулалт, хөгжлийн газар, мэргэжилтэн **Б.Анхтөр**

- Иж бүрэн гүйцэтгэлийн байрзүйн зураг хийлгэж Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд оруулах. (Ажлын файл шалгуулах);
- Батлагдсан загвар зургийн дагуу гадна тохижилт, зам талбайн гадна тохижилт, зам талбайн ажлыг хийж гүйцэтгэх;
- Гадна цахилгааны зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх;
- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчилж ирүүлэх. (Барилга болон шугам сүлжээнд орсон өөрчлөлтийг тусгах);
- Захиалагчийн нэгдсэн зүгнэлт ирүүлэх;
- Гүйцэтгэлийн зургийг баталгаажуулж ирүүлэх;
- Санал: Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах;

Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Газар ашиглалт, барилга байгууламжийн хяналт хариуцсан мэргэжилтэн **Д.Сугар**

- Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт;

ШАЛГ
ГАЗАР
ламжий
улах ком

- Газар эзэмших эрхийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх акт;
- Дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх;
- Илүү талбайн асуудлыг шийдвэрлэх, зөрчлийг арилгах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй;

Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч **Ж.Худэрчулуун**

- Гадна цахилгаан зураг хянуулаагүй комисс ажиллаагүй;
- Гадна КТПН, дулааны узель барилгаас 2.5 метр зайтай. Зай хэмжээ алдагдсан;
- БНГД 40-05-16-ийн 5.5 д усан хангамж төлөвлөсөн боловч шугам гагнасан, шугам, хоолойг багасгасан;
- Дээвэрт ашигласан сендвич, гадна фасаданд ашигалсан хөөсөнцөр материалын ГСҮХ-ийн дүгнэлт шалгуулах;
- МУГАБТХ-ийн 17.2.3 дээвэрт өөрчлөлт оруулж төлөвлөсөн. /Авторын дүгнэлт шинэчлэх/;
- Амрах өрөө бүрт төлөвлөсөн орон байрлуулсан розеткийг ашиглахгүй болгох;
- Амрах өрөө бүрт агааржуулалт төлөвлөөгүй;
- Санал: Зөрчил дутагдал засаж арилган фото зураг, албан бичгээр ирүүлэх. /Ажлын 14 хоногт багтаах/

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын эрхэлэгч **Я.Чулуун**

- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримтаа брдүүлэх;
- Баримт бичгийг архивын заавар, журмын дагуу цэгцлэх. /Нүүр хуудас, дотоод товьёог үйлдэх, хуудас харандаагаар дугаарлах/;
- Ажлын зураг болон үндсэн баримтын эх хувийг хүлээлгэн өгөх;
- /archives.gov.mn/ сайт – түгээмэл асуулт хариулт – зураг төслийн баримт цэгцлэх, хүлээлгэн өгөх цэс рүү орох;
- Санал: Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах боломжтой;

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах хэлэс, Норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах**

- Дотор хана, хамар ханын хучилтын бэхэлгээ хийсэн акт, фото зураг үзүүлэх;
- Дээврийн усны хаялганы буултыг хаявчнаас дээш 30 см хүртэл буулгах;
- 1-р давхрын ажлын өрөөнүүдийн цонхны өндөр 1900 мм байхаас 500 мм-ээр хийсэн. Зохиогч байгууллага тайлбар, албан бичиг ирүүлж, Зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах;
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг бодуулж, төлөх;
- Санал: Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Болормаа**

- Гадна пандусыг стандартын дагуу бариул хийх;
- Явган хүний замаас зам руу орох налуулалт хийх;
- Төкний өндөрийг стандартын дагуу 80 см-ээс багагүй хийх;
- ХБ ариун цэврийн 1, 2 давхар өрөөнд ХБИ-нд зориулсан тоноглол хийх;
- ХБИ-нд зориулсан авто машины зогсоолын босоо, хэвтээ тэмдэглэгээ хийх;

Ашиглалт хариуцах байгууллага, Глобал Сивик Шэйринг ТГ-ын захирал **Н.Батдорж**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, барилгыг ашиглалтад авахыг зөвшөөрч байна;

Зураг төсөл зохиогч байгууллага Уран үзэг ХХК-ийн захирал, архитектор **Ө.Эрдэнэгэрэл**

- Гадна үүдний гадаргын ус зайлуулах тал дээр анхаарах;
- Уулын налуу хэсэгт тойруулан шуудуу хийх;
- Барилгын ард хурын ус тогтохгүй байхаар тооцож гадна тохижилтын уклоныг сайн хийх;
- Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгавар биелүүлэлтээр байнгын ашиглалтад өгөх боломжтой;

Барилгын гүйцэтгэгч байгууллага Роуд девелопмент ХХК-ий захирал **М.Батсайхан**

- Санал байхгүй болно.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Глобал Сивик Шэйринг ТГ-ын захиалгатай, зоорьгүй 2 давхар 1 блок Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг байнгын ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ,
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ (А.МӨНГӨН)

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ ТГ-ЫН
ЗАХИРАЛ (Н.БАТДОРЖ)

СХД, 21-р хороо, [illegible] [illegible] [illegible] 11-11, [illegible]
[illegible] [illegible] [illegible] үйлдвэрийн [illegible] 133

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

26/143

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Хотын стандарт, хяналтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга

Комиссын нарийн бичгийн дарга: О.Оджаргал

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) БНбД 11-04-16 дагуу зохиолт дүгнэлт бичих. | — |
| 2) БТХ-ийн дагуу барилгын [illegible] [illegible] [illegible] [illegible] тоотоо [illegible]. | — |
| 3) Барилгын [illegible] дагуу [illegible] [illegible] [illegible] [illegible] | [illegible] |
| 4) [illegible] [illegible] хүртэл [illegible] [illegible] [illegible] [illegible]. | [illegible] |
| 5) [illegible] [illegible] [illegible] [illegible] [illegible]. | [illegible] |
| 6) [illegible] [illegible] [illegible] [illegible]. | [illegible] |
| 7) Автор хяналт болон [illegible] [illegible] [illegible], [illegible] [illegible] [illegible] | — |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 өдөр

СХД, 21-р хороо, Нэгдэл [illegible] [illegible] 11-н, Хороо ах [illegible] [illegible] [illegible] 139

| | |
|---|---|
| Тайлбар өгөх тоот ирүүлэх<br>⑧ 1, 2-р дэвсгэр газ, шатахуун хэрэглэх (цахилгаан халаалт) тайлбар ирүүлэх (зохиол, [illegible], [illegible]) — | |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/О.Оджаргал / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/О.Оджаргал/ Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2026.03.03 |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05-ний өдөр

(2)
140

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

СХД-ийн 21-р хороо
Хорго-ын ахуйн дүрган
барилга Эдевхар

Байгууллага: Хотын стандарт, хяналтын газар, БСАБХХ БТХЗАБайцаагч
Комиссын гишүүн: Ж. Нурдэрмаа

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Дээврийн ус зайлуулах хоолойг угсарч, хучилтын ороолтгүй гүйцэтгэсэн зураг төслийг хянуулж зохиогчийн дүгнэлт гаргах, захиалагчаас ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах талаар тайлбар баталгаа гаргах.<br>Үүрэг даалгаврыг биелүүлбэл ашиглалтад оруулах саналтай. | 1. Дээврийн ус зайлуулах хоолойг угсарсан фото зураг ирүүлсэн, АДД ХХК-ийн гүйцэтгэлийн зураг төслийг хянаж зохиогчийн дүгнэлт гаргасан, захиалагчаас ашиглалтын үеийн засварыг цаг тухайд нь гүйцэтгэх талаар 2024.04.29-ний өдрийн 24/032 дугаартай тайлбар ирүүлснийг хянаж баталгаажуулав.<br>✓ |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг [signature]
20 26 оны 03 сарын 05 ний өдөр

| | |
|---|---|
| | |
| Үүрэг даалгавар өгсөн: Үүрэг даалгаврын биелэлтэд анхааралтай авах<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/:<br>М.Жаргалмаа Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16. | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>М.Жаргалмаа Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.29 |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05-ний өдөр

СХД-21-р хороо [illegible]

[illegible] Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

[illegible]

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Нийслэлийн эрүүл мэндийн газар

Комиссын гишүүн: [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) [illegible] | 1) [illegible] |
| 2) [illegible] | 2) [illegible] (2018.06.12 [illegible]) |
| 3) [illegible] | 3) [illegible] № 2176 [illegible] (2024.04.29) 14 [illegible] |
| 4) [illegible] | 4) [illegible] |
| 5) [illegible] | 5) [illegible] |

143

| | |
|---|---|
| 6) Бохир усыг зайлуулах талаар үйлдвэрлэлийн технологи [illegible] оруулах, лаг бохир үйлдвэрлэсэн бохир усны [illegible] [illegible], [illegible] [illegible] ҮА-г хангах [illegible] [illegible] оруулах мэргэжлийн хүмүүс ажиллуулах. | 6) Сумын [illegible] бохир усны технологийн [illegible] оруулах. 2014.04.28-ны 24/03 албан бичгээр [illegible] [illegible] хүсэх тухай [illegible] оруулав. |
| 7/ Үйлдвэр усан [illegible] [illegible] [illegible] [illegible] оруулах | 7/ [illegible] [illegible] ХХК-ийн 2014.04.28-ний [illegible] [illegible] [illegible] [illegible] хэсэгт [illegible] оруулав |
| 8/ [illegible] [illegible] [illegible] [illegible] [illegible] | 8/ [illegible] – ийн [illegible] [illegible] [illegible] оруулсан |
| Үүрэг даалгавар өгсөн: [signature]<br>Гарын үсэг: [signature]<br>/Тамга, тэмдэг/ [stamp]<br>/ П. [signature] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2014.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: [signature]<br>Гарын үсэг: [signature]<br>/Тамга, тэмдэг/ [stamp]<br>/ Р. [signature] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2014.04.29 |

Бүртгэлийн дугаар ........511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
[signature]
2026 оны 03 сарын 05 ний өдөр

144 (4)

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Монгол цахилгаан ХХК.

Комиссын гишүүн: А. Анхбаяр. УБТЗ-н эрчим хүч [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| - Цахилгааны ерөнхий шитэнд ерөнхий [illegible] хийх туршилт | Ерөнхий [illegible] [illegible] хийсэн |
| - Гал түймрийн дохиолол байрын цахилгааны шитнээс кабель их холбогдсон холболтыг хийх | Гал түймрийн дохиолол кабелиар холболтыг хийсэн |
| - Цахилгааны шитнээс гарсан утас шитний их биед хүрсэн тул холболтыг хийх /бүх шитэнд/ | Цахилгааны [illegible] гаргалгааг кабелиар холболтыг хийсэн |
| - Бохирын ерөнхий цахилгааны розетк ус шүүрний холболтгүй тул үе газардуулгатай розеткоор солих | Ус газардуулгатай холболттой розетк солисон. |
| - Цахилгааны шитэнд [illegible] холбогдсон ноль-ийн [illegible] салгаж холбох. | Ноль холболт салгасан |
| - Ашрах [illegible] ерөнхий [illegible] розетк авах. | Ашрах ерөнхий розетк авсан |

Бүртгэлийн дугаар ....571.......
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

145

| | |
|---|---|
| | |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг: [signature]<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг: [signature]<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.29. |

Бүртгэлийн дугаар ...511...
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
[signature]
2024 оны 05 сарын 05 ...

146 (b)

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК – СХД, 21-р хороо.

Комиссын гишүүн: Н.Даваадэлгэр – Глобал Сивик Шейрингс-ТТ – Хөдөө от агуйн ҮСТ барилга

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт 2024.-04-16 |
|---|---|
| 1) Мобинет төв шилэн кабелийг салаалж авсан газраас өөрийн сургуулийн төв хүртэл газраар татсан шилэн кабелийн трассыг мэдээллийн санд оруулан гүйцэтгэгч компаниас авах. (комиссын үйл ажиллагаанд бэлэн байлгах) | |

Бүртгэлийн дугаар 571
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
20[26] оны [03] сарын [05] ...

| | |
|---|---|
| Үүрэг даалгаврыг зөвлөмж ёсоор ашиглалтад авах саналтай байна. | Үүрэг даалгаврын шийдэл хүлээн авав. |
| Үүрэг даалгавар өгсөн: МХС-ТӨХК.<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/Н.Даваадорж/ Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024-04-16. | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: МХС.<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/Н.Даваадорж/ Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024-04-24. |

Бүртгэлийн дугаар ...511...
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 ний өдөр

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

СХД 21-р хороо
Глобал Сивик Инжиниринг ТӨ

Байгууллага: Хот байгуулалт, хөгжлийн газар

Комиссын гишүүн: Б. Анхтөр

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Иж бүрэн шийдлийн байршлын зураг хийлгэж Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд оруулах. (Авто кад файл шалгуулах) | 1. Хот байгуулалтын мэдээллийн санд шалгасан. |
| 2. Батлагдсан загвар зургийн дагуу гадна тохижилт, зам талбайн ажлыг хийж гүйцэтгэх. | 2. 2024.05.02-ны өдрийн 24/038 дугаартай албан бичгээр тайлбар, фото зураг ирүүлсэн. |
| 3. Гадна цахилгааны зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцүүлэх. | 3. Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн нэгжээр ачилттай ашиглалтын үйлчилгээний гэрээ байгуулсан гэрээ ирүүлсэн. |

...ийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

| | |
|---|---|
| 4. Зураг төсөл зохиогчийн иждэж дүгнэлтийг шалгалт ирүүлэх. (Барилга болон инженерийн шугам сүлжээнд орсон өөрчлөлтийг тусгах)<br><br>5. Захиалагчийн иждэж дүгнэлт ирүүлэх.<br><br>6. Гүйцэтгэгчийн зургийг баталгаажуулж ирүүлэх.<br><br>Санал: Үүрэг даалгаврыг биелэлтэй ангилалтад авах. | 4. Зураг төсөл зохиогчийн<br><br>5. Захиалагчийн иждэж дүгнэлт ирүүлсэн.<br><br>6. Зу Гүйцэтгэлийн зураг ирүүлсэн. |
| Үүрэг даалгавар өгсөн: ХБХГ<br>Гарын үсэг: Б. Анхтөр<br>/Тамга, тэмдэг/<br>Б. Анхтөр / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: ХБХГ<br>Гарын үсэг: Б. Анхтөр<br>/Тамга, тэмдэг/<br>Б. Анхтөр / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.05.02 |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2024.04.16 150 (1)

СХД 21-р хороо

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

Хөдөө аж ахуйн үйлдвэрийн цогцолбор.

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Газар ашиглалт, барилга байгууламжийн хяналт хариуцсан мэргэжилтэн

Комиссын гишүүн: Д.Сугар „Глобал сивик шейринг" ТТ

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| ЗЗД-н 2022.01.24 1801907155, 74.940м² | А/15 СХД 21-р хороо ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор |
| • Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт<br>• Газар эзэмших эрхийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх акт<br>• /Дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх/<br>• Илүү талбайн асуудлыг шийдвэрлэх, зөрчлийг арилгах<br>– Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд | 2024.05.06-ны өдрийн №01116-2022/01414 тоот тооцоо нийлсэн акт авсан ба.<br>2024.05.06-ны №007 тоот гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх акт авсан байна.<br>ДХАУ- 2024.05.05-нд 85'799'440 төг төлсөн ба.<br>Илүү талбайг хасаж зөрчлийг арилгасан тухай фото зураг хавсаргасан. |

авахад татгалзах зүйлгүй.

Бүртгэлийн дугаар ......
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

051

| | |
|---|---|
| | |
| Үүрэг даалгавар өгсөн: НГЗБА<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ Д. Сугар / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ Д. Сугар / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.05.06 |

Бүртгэлийн дугаар ... 571
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 ний өдөр

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн
Барилгын зураг төслийн хяналтын /ахлах/ байцаагч СХД-21-р хороо Глобал сивик

Комиссын гишүүн: Ж.Хүдэрчулуун. Шэйрнг ХХК.

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| ① Гадна цахилгаан зураг хянуулаагүй, комисс ажиллаагүй. | |
| ② Гадна КТПН, дулааны узел барилгаас 2,5м зайтай /зай хэмжээ алдагдсан/ | 2020 оны 05 сарын 07-ны өдрийн 24/045 тоот албан бичгээр |
| ③ БНбД 40-05-16-н 5.5. дотор усан хангамж төлөвлөсөн боловч шугам гагнасан, шугам хоолойг багасгасан. | дагуу хийсэн ажлын тайлан болон, цаашид хийж гүйцэтгэх ажлын тайланг фото зургийн хамт авч баталгаажуулав /хавсралт хавсаргав/ |
| ④ Дээвэрт ашигласан сэндвич, гадна фасаданд ашигласан хөөсөнцөр материалын ГТҮХ-н дүгнэлт шаардлагах. | |
| ⑤ МУГАБТХ-н 17.2.3 дээвэрт өөрчлөлт оруулж төлөвлөсөн /авторын дүгнэлт шинэчлэх/ | |
| ⑥ Амрах өрөө 5-рт төлөвлөсөн оронд байрлуулсан розеткаг ашиглахгүй болгох. | |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон албаны гарын үсэг

| | |
|---|---|
| (7) Амрах өрөө бүрт агааржуулалт төлөвлөгдсөн.<br><br>Санал<br><br>Зөрчил дутагдал засах арилгаж фото зураг, албан бичгээр ирүүлэх /ажлын 14 хоногт багтаах/ | |
| Үүрэг даалгавар өгсөн: БЗТХАБ, д/ж<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: БЗТХАБ, д/ж<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.05.07 |

Бүртгэлийн дугаар ......511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 өдөр

[illegible]
154 (4)

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ХАА-н үйлдвэр сургалтын төвийн барилга.

Комиссын гишүүн: Я. Чулуун

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримтаа бүрдүүлж.<br>2. Баримт бичгийг архивын заавар, журмын дагуу цэгцлэх. /нүүр хуудас, дотоод товъёог үйлдэх, хуудас нарийвчлан дугаарлах/<br>3. Анхны зураг бүх үндсэн баримтын эх хувийг хүлээлгэн өгөх. | |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2016-03-05 он сар өдөр

| | |
|---|---|
| /archives.gov.mn/ сайт/<br>=> Түгээмэл асуулт<br>хариулт => Үүрэг<br>[illegible]<br>[illegible] . [illegible]<br><br>Ср.а. Комиссын гишүүдийн<br>үүрэг даалгаврыг<br>биелүүлэх ажиллагаанд<br>оруулах боломжтой. | |
| Үүрэг даалгавар өгсөн: [illegible]<br>Гарын үсэг: Я. Чулуун<br>/Тамга, тэмдэг/<br>/ Я. Чулуун / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ Я. [illegible] / Гарын үсгийн тайлал<br>Огноо: УХА0123 0087388 |

Бүртгэлийн дугаар ...911...
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05-ний өдөр

158 (10)

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

"Глобал Сивик Шейринг" ХХК

Байгууллага: Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн

Хөдөө аж, ахуйн үйлдвэрийн цогцолбор /Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо/

Комиссын гишүүн: О. Ундрах.

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| ①. Цотор хана, хаалга. Хаалганы хугилалтын бэхэлгээ хийсэн. Акт. фото зураг үзүүлэх. | - Орлогоны хаалганы хугилалтын бэхэлгээ. хийсэн акт, фото зураг нөхөн үзүүлэв. |
| ②. Цэвэр усны хаягны бүлтийг хаяавсанаас дээш 30 см хүртэл булах. /6.7.8.9/ | - Цэвэр усны. хаягны бүлтийг булсан фото зураг хавсаргав. |
| ③. 1-р давхрын онгоны өрөөнүүдийн цонхны 1900 мм өндөртэй байхаас 500 мм-ээр хийсэн. Зохиогч байгууллагын тайлбар албан бичиг ирүүлж, Зохиогчоор нэгдсэн дүгнэлтэд тусгах. | - Зохиогч байгууллагын 2024-04-26-ны албан бичиг 2024-04-25-ны 89 дугаартай зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусган ирүүлэв. |
| ④ Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны | - Норм, нормативын тол бичиг толов, |

Бүртгэлийн дугаар 611
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

| | |
|---|---|
| дагуу норм, нормативын төлбөрийг бодолцон төлөх. | |
| Санал: Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр оруулах. | Өгөгдсөн үүрэг даалгавар биелэгдсэн байна. |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг: [signature]<br>/Тамга, тэмдэг/ МОНГОЛ УЛС 19-405 Оюунбатын УНДРАХ МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР МА-БА 2023-2027<br>/ О. Ундрах / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024-04-16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг: [signature]<br>/Тамга, тэмдэг/<br>/ О. Ундрах. / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024-04-30. |

Бүртгэлийн дугаар ......511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 он 03 сар 05 өдөр

158 (11)

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага

Комиссын гишүүн: Б. Болормаа СХД 11-р хороо Хороо ахлах сахиул Глобал с үйлдвэрлэл сургалтын төв.

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
| --- | --- |
| 1) Гаднах пандусыг стандартын дагуу барьж хийх. | Биелсэн |
| 2) Явган хүний замаас зам руу орох налуулалт хийх. | |
| 3) Техникийн өндөршил стандартын дагуу. 80см багасгаж хийх | |
| 4) ХБ Ариун цэврийн 1-2 давхар өрөөнд ХБИ зориулсан тоноглол хийх | Биелсэн |
| 5) ХБИ-д зориулсан авто машины [illegible] зогсоолын босоо хэвтээ тэмдэглэгээ хийх. | |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 06

159

| | |
|---|---|
| 7<br><br>Үүрэг даалгаварыг биелүүлэр байгууллагын ашиглалтанд оруулах санал тавь б/а | |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/Б.Болормаа / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/Б.Болормаа / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.05.01 |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 05 сарын 05 өдөр

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Ашиглалт хариуцах байгууллага: Глобал швак шейрин ХХ

Комиссын гишүүн: Н. Баздорж

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
| --- | --- |
| 1) Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хангалт барилгыг ашиглалтад авахыг зөвшөөрч байна. | 1) Комиссын гишүүдийн үүрэг, даалгавар биелүүлсэн. |

Бүртгэлийн дугаар ....511....
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
20 26 оны 03 сарын 05-ний өдөр

| | |
|---|---|
| | |
| Үүрэг даалгавар өгсөн: И. Ганзориг<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>И. Ганзориг Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>И. Ганзориг Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.05.06 |

Global Civic Sharing
Global Civic Sharing

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 өдөр

162 13

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Зураг төсөл зохиогч байгууллага: Урам үйл ХХК

Комиссын гишүүн: Архитектор, ХАС инженер М. Хайрхан [illegible]

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) Гадна дулааны гадаргын ус зайлуулах шугам анхаарах. | 1) Сургалтын төвийн зүүн талаар дулааны хэсэгт шугам татаж хийсэн байна. |
| 1) Цонхны налуу хэсэгт байгаа тойруулан шугам хийх. | 1*) Шугам татаж хийсэн байна |
| 2) Барилгын ард хуримтлагдах ус тогтоохгүй байхаар тооцох. Гадна тохижилтын ажлыг сайн хийх. | 2) Тохижилтын ажил хийсэн байна |

Бүртгэлийн дугаар ...511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
[signature]
2016 оны 03 сарын 05 ний өдөр

| | |
|---|---|
| Компанийн үзсэн гүйцэтгэгчийн үүрэг даалгавар. биелүүлэгч. байгууллага ашиглалтанд өгөх боломжтой. | биелсэн байна. |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ Эрдэнэзул / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024-04-16. | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/Д. Эрдэнэзул/ Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024-04-06. |

Бүртгэлийн дугаар ......511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 ний өдөр

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын
дүгнэлтийн хамт хүчинтэй)

Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага: Родд девелопмент ХХК

Комиссын гишүүн: Бэйсайхан

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| Санал байхгүй болно. | Санал байхгүйсэ. |

Бүртгэлийн дугаар ...571...
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 ний өдөр

165

|  |  |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: УЛААНБААТАР ХОТ<br>Гарын үсэг: РОУД<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.04.16 | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг: УЛААНБААТАР ХОТ М.Батсайхан<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: 2024.05.09 |

Бүртгэлийн дугаар 511
ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
2026 оны 03 сарын 05 өдөр

ROAD DEVELOPMENT
**РОУД ДЭВЭЛОПМЕНТ ХХК**
УБД 9011370047, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
1 дүгээр хороо, 120 мянгат 10-р байр 2 тоот
Утас: 8811-4525, 976-7737-4525
И-мэйл: road2007b@gmail.com
Вэб: www.road.mn

2024.04.16 № 184/24
танай ________ -ны № ________ -т

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ГАЗАРТ

Барилга байгууламжийн чанарт
гүйцэтгэгч байгууллагаас
гаргасан баталгаа

Зураг төслийн "Уран үзэг" ХХК-д боловсруулсан УЗ-06/2021 шифр бүхий зураг төслөөр нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Рашаант хэсэг Ухны ам байршилд буй баригдсан Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилга угсралтын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 20 ны өдрөөс эхэлж 2024 оны 04 дүгээр сарын 16 ны өдөр байнгын ашиглалтад авах улсын комиссыг ажилуулсан.

Захиалагч Глобал сивик шэйринг төлөөлөгчийн газартай 2022 оны 04 дүгээр сарын 27 өдөр байгуулсан Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн 2022/001 тоот гэрээний тусгай нөхцөлийн 1.7-д заасны дагуу энэ өдрөөс эхлэн 2028 оны 04 дүгээр сарын 16 өдөр хүртэл 4 жилийн хугацаанд чанарын баталгаа гаргаж байна.

Чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн зөрчил гологдол илэрвэл "Барилгын тухай" хуулийн 14.3, 14.6 дугаар заалтын дагуу зөрчлийг арилгаж арга хэмжээ авна.

Чанарын гологдол, зөрчил илэрсэн тохиолдолд эзэмшигч /ашиглагч/ байгууллага 10 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад мэдэгдэнэ.

Чанарын баталгаат хугацаанд эзэмшигч, ашиглагч байгууллагуудын буруутай үйл ажиллагаанаас үүссэн эвдрэл гэмтэл нь энэ баталгаат хугацаанд хамаарахгүй.

Баталгаа гаргасан: 2024 оны 04 сарын 16
Гүйцэтгэгчийн нэр: Роуд дэвэлопмент ХХК
Гэрчилгээний дугаар: 9011370047
Тусгай зөвшөөрлийн дугаар: БУ18-671/21
Хаяг: ХУД 1-р хороо 120,0 мянгат 10-2
Утас: 88114525, 77374525

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.БАТСАЙХАН

Global Civic Sharing

**“ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ” ТГ**
9093907 Улаанбаатар хот, Сонгинохайрхан
дүүрэг, 21-р хороо, Жаргалант тосгон,
Рашаант өртөө, Ухны ам 1-1
Утас: 90116046 80044088

2026.03.02 № 26/017
танай ________________ -ны № _____

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ГАЗАРТ

Хүсэлт хүргүүлэх тухай

Та бүхний ажилд өндөр амжилт хүсэн ерөөе.

Манай Глобал Сивик Шэйринг төрийн бус байгууллага нь 2021-2025 оны хугацаанд хэрэгжүүлсэн “Хүртээмжтэй мал аж ахуй” төслийг хэрэгжүүлэхэд 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газартай Санамж бичиг байгуулан өнөөг хүртэл амжилттай хамтран ажиллаж байна.

Төслийн хүрээнд орон нутгийн малчид, хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийг чадавхжуулах “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төв”-ийн барилга угсралтын ажлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гүйцэтгэж 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Барилга байгууламжийг байнгын ашиглалтад авах комисс ажилласан билээ.

Дээрх Барилга байгууламжийг байнгын ашиглалтад авах комиссын 14 гишүүнээс нийт 56 үүрэг, даалгавар өгсөн ба үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангаж хүргүүлсэн боловч комиссын дарга О.Оджаргалын зүгээс цахилгааны холбогдох шийдвэрүүдийг албажуулах шаардлага тавьсан.

Мөн холбогдох хүсэлт, материалыг төрийн үйлчилгээний цахим системээр ирүүлэх шаардлага тавьсны дагуу хүсэлт илгээхээр оролдсон боловч Гадаадын иргэн харьяатын газарт бүртгэлтэй байгууллагууд Төрийн үйлчилгээний Хур Дан системд ороогүй, шалтгаанаар цахим үйлчилгээ авах боломжгүй байсаар өнөөг хүрсэн нь ажил удаашрах нөхцөл болсон.

Манай байгууллага эрчим хүчний хангамжаа Улаанбаатар төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн нэгдүгээр ангиас авдаг бөгөөд тус байгууллагын зүгээс олгосон техникийн нөхцөлийн дагуу комисс ажиллаж, дүгнэлт гаргасны үндсэн дээр гэрээ байгуулж эрчим хүчээр хангагддаг болно.

Иймд тус барилгын цахилгаан эрчим хүчээр хангагч Төмөр замын эрчим хүч, ус хангамжийн нэгдүгээр ангийн тодорхойлолтыг эх хувиар, эрчим хүчний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой техникийн нөхцөл, комиссын протокол, шинээр баригдсан шугам сүлжээ, дэд станцыг хүчдэлд холбох зөшөөрөл, ашигалт үйлчилгээний гэрээний хуулбарыг тус тодорхойлолтын хавсралтаар хүргүүлж байгааг хянан үзэж тус барилгыг байнгын ашиглалтад хүлээн авахыг хүсье.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ Н.БАТДОРЖ

- Зохиогчийн хяналтын дүгнэлт 2
- Ашиглалтын тайлбар

„УРАН ҮЗЭГ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 4-р хороо, Сөүлийн гудамж 49-16
Утас: -976 11323281, -976 89064595
Mail: uranuzeg@yahoo.com

2024.04.26 № 29

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 21-Р ХОРООНД БАРИГДСАН СУРГАЛТЫН ТӨВИЙН БАРИЛГЫН АЖИЛД ЗОХИОГЧИЙН ҮЗЛЭГ ХИЙСЭН ТУХАЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Манай байгууллагын боловсруулсан зураг төслөөр, гадны хөрөнгө оруулалтын хүрээнд. Сонгиохайрхан дүүргийн 21-р хорооны газарт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилгыг “Роуд дэвэлоупмент”ХХК-ээр барьж гүйцэтгүүлсэн болно.Тус барилгыг угсралтын үе шатны ажлын явцад манай инженер техникийн ажилтнууд нийт 7 удаа хяналт хийж 15 заалт бүхий шаардлага , заавар зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллаа. Тавьсан шаардлага өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан болохыг тэмдэглээд.

1.Барилга угсралтын талаар, сургалтын төвийн каркасан барилгын угсралтын ажил нь барилгын зураг төслийн авторын хяналтын гэрээний дагуу, барилга угсралтын явцад шалгагдаж суурь, багана, хучилтанд шаардагдах чанартай УСТ-ын шаардлага хангасан арматур, бетоноор дулааны улиралд цутгагдаж ,барилгын зураг төслийн дагуу хийгдсэн байна.

Барилгын ажлын явцад ашиглагч ,захиалагч байгууллагуудтай зөвшилцсөнөөр барилгын гадна дээврийн хийцлэлийг өөрчлөлтийн зураг гаргуулан сэндвич хэлбэртэй болгон хийж гүйцэтгэсэн болно. Мөн гадна,дотор дулаан, цахилгаан зэрэгт өөрчлөлт орсонг өөрчлөлтийн зураг хийж баталгаажуулсан байна.

2. захиалагч байгууллагын санал хүсэлтээр агуулахын өрөө төлөвлөж, 1-р давхрын зарим өрөөний цонхыг жижгэрүүлсэн мөн халаалт, сантехникийн системийн угсралтын ажлууд нь чанартай хийгдсэн гэж үзэж байна.

Нэгдсэн дүгнэлтэнд нэмж тэмдэглэх нь:
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилга нь Зураг төсөл , норм дүрмийн шаардлагуудыг зөрчөөгүй хэвийн баригдсан гэж үзэх тул ашиглалтад хүлээн авах боломжтой гэсэн дүгнэлт гаргаж байна.

Жич: Захиалагч байгууллагын 2024-04-26 өдрийн 24/031 тоот албан хүсэлт.
Гүйцэтгэгч байгууллагын 2024-04-24 өдрийн 0018 тоот тодорхойлолтыг хавсаргав.

Дүгнэлт бичсэн:
Барилгын зураг төслийн
“Уран үзэг” ХХК-ийн захирал Ө.Эрдэнэгэрэл

Зохиогчийн хяналт
дүгнэлт 3
- Ажлын тайлбар

# БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

2024 он 05 сар 03 өдөр Улаанбаатар хот

1. **Хяналт хийсэн барилгын нэр, байршил, хаяг:**
   Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төв
   Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, Рашаант хэсэг, Ухны ам 1-1 тоот
2. **Зохиогчийн хяналтын гэрээний дугаар: ЗХ-01/2022**
   Захиалагч “Глобал Сивик Шэйринг” ТГ-тай 2022 оны 05-р сарын 12-ны өдөр байгуулсан **“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төв”**-ийн барилгын зураг төсөв, хяналтын ажил гүйцэтгэх ЗХ-01/2022 тоот гэрээ.

   **Зураг төсвийн байгууллага:** “Уран үзэг” ХХК /РД: 5697484/

   **Барилгын ажлын зургийн ерөнхий шифр: УЗ-06/2022**
3. **Зохиогчийн хяналт гүйцэтгэсэн хугацаа:** 2022 оны 05-р сарын 19-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл барилга угсралтын ажил гүйцэтгэх хугацаанд барилга угсралт, дотор инженерийн шугам сүлжээний угсралт, дотор засал, гадна тохижилтын ажилд зохиогчийн хяналтыг гүйцэтгэв.
4. **Зохиогчийн хяналтын төрөл:**
   Үе шатны хяналт
5. **Зохиогчийн хяналт хийсэн ажлын төрөл:**
   Барилга угсралт, дотор инженерийн шугам сүлжээний угсралт, дотор засал, гадна тохижилтын ажилд
6. **Зохиогчийн хяналт гүйцэтгэхэд мөрдсөн бичиг баримт:**
   - Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Н.Нацагдоржийн баталсан 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн МЗХ2022/03-004 тоот Архитектур төлөвлөлтийн даалгавар.
   - “Уран үзэг” ХХК-ий боловсруулсан УЗ-06/2022 шифр бүхий 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 725/2022 тоот магадлалаар батлагдсан зураг төсөл.
7. **Зохиогчийн хяналтын явцад батлагдсан зураг төслөөс өөрчлөгдсөн ажлууд:**
   - Захиалагчийн хүсэлтээр дээврийн дулаалга, хучилтын ажлыг төмөр рам зангидаж сэндвичээр хучиж, усны хаялгыг барилгын ар тал руу гарахаар шийдсэн.
   - Дээрхитэй холбоотой агааржуулалтын ердийн системийг автомат систем болгон өөрчилсөн.
   - Зураг төсөлд барилгын дулааны систем нь радиатораар төлөвлөгдсөн байсныг захиалагчийн хүсэлтээр шалны халаалтын системээр өөрчилсөн.
   - Захиалагчийн хүсэлтээр Ү3-Х3 дагуу агуулахын өрөө төлөвлөж, гүйцэтгэсэн.
   - Барилгад цахилгааны самбар 1 ширхэг төлөвлөгдсөн байсныг захиалагчийн хүсэлтээр 2 хэсэг болгож дулааны цахилгаан хангамжийн хэсгийг барилгаас тусдаа байрлах 10х6 метр техникийн өрөөнд байхаар шийдсэн.
   - 1, 2 дугаар давхарт угаалтуурын тоо 12 ширхэгийг төлөвлөсөн байсныг захиалагчийн хүсэлтээр 18 болгон нэмэгдүүлсэн.
   - 1, 2 дугаар давхарт эрэгтэй бясаагуурын тоо 1 байхаар төлөвлөсөн байсныг 7 болгон нэмэгдүүлсэн.
8. **Зохиогчийн хяналтын явцад гарсан зөрчил, дутагдлыг арилгах талаар тавьсан асуудлууд, тэдгээрийн биелэлт:**

- Барилгын суурийн -1.08 түвшний суурийн арматурчлалын хомутын алхам бага зэрэг хол байсныг 100мм болгосон.
- +2.92 түвшний арматурчлал, арматурын зөрүүлэг, хамгаалалтын үенд туслах дам нурууны анкерлалтыг хангуулж арматурыг засварлуулсан.
- ЦДН-6 анкер хангахгүй байсанг нэмэлтээр 4шФ22А400 1200мм урттайгаар 600 мм зөрүүлэх шаардлагатайг хангуулсан.
- Захиалагчийн хүсэлтээр 1-р давхарын 6, 7, 8, 9, 10, ариун цэврийн өрөөнүүд, дулааны техникийн өрөөний цонхнуудын хэмжээ 1900мм өндөртэй байсныг 500мм болгон өөрчилсөн.
- Хучилтын доод үеийн арматур зарим хэсэгт дутуу анкерлагдаж байгааг сануулж, засуулсан.
- Дам нуруу, баганын хамгаалалтын үеийг хангуулсан.
- Үндсэн дам нурууны арматур зэврэлттэй байгааг цэвэрлүүлсэн.
- Цутгамал дам нуруу ЦДН-5 /позиц 32/ арматурыг хамгаалалтын үеийн зургийн дагуу засах шаардлагатай байсныг засуулсан.
-

## 9. Барилгыг ашиглалтад оруулах тухай зохиогчийн дүгнэлт:

Манай байгууллагын боловсруулсан зураг төслөөр гадаадын хөрөнгө оруулалтын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны газарт Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилгыг “Роуд Дэвэлоупмент” ХХК гүйцэтгэсэн. Барилга угсралтын үе шатны ажлын явцад манай инженер техникийн ажилтнууд нийт 7 удаа хяналт хийж 15 заалт бүхий шаарлага, заавар, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажилласан болно. Зохиогчийн зүгээс тавьсан шаардлага, өгсөн зөвлөмжийг захиалагч болон барилга угсралт гүйцэтгэгч нар хэрэгжүүлж ажилласан болно. Үүнд:

Барилга бүтээц: Зохиогчийн хяналтын гэрээний дагуу барилга угсралт нь суурь, багана, дам нуруу, хучилтад чанартай, УСТ-ийн шаардлага хангасан арматур, бетоноор дулааны улиралд цутгагдаж, барилгын зураг төслийн дагуу хийгдсэн.

Халаалт, агаар сэлгэлт: Барилга угсралт, заслын ажлын явцад 2 жилийн турш ажиллуулсан ба алдаа доголдол үүсээгүй.

Цэвэр бохир ус: Сайн чанарын нерж хоолойгоор цэвэр усны системийг шийдсэн ба алдаа доголдолд илрээгүй, гүйцэтгэл чанартай, сайн хийгдсэн.

Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг: Гүйцэтгэл сайн.

Холбоо дохиолол: Гүйцэтгэл сайн.

**Дүгнэлт гаргасан:**

Архитектор: /Ө.ЭРДЭНЭГЭРЭЛ/

Барилгын инженер: /Н.ЭНХЧИМЭГ/

ХАС инженер: /М.ХАЙРОШ/

Цахилгаан инженер: /Г.ЭНХЧИМЭГ/

Холбооны инженер: /Ө.МӨНХГЭРЭЛ/

Global Civic Sharing

**“ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ” ТГ**
9093907 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, Жаргалант тосгон, Рашаант өртөө, Ухны ам 1-1
Утас: 90116046 80044088

2024.05.07 № 24/049
танай ______________ -ны № _____

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАРТ

Үүрэг даалгавар биелүүлсэн тухай

Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсье

Манай “Глобал Сивик Шэйринг” төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй “Хүртээмжтэй мал аж ахуй” төслийн хүрээнд барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр ажилласан билээ.

Тус комиссын хурлын шийдвэрээр Нийслэлийн онцгой байдлын газрын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг дараах байдлаар биелүүлсэн болно. Үүнд:

| д/д | Үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|---|
| 1 | БНГД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих. | БНГД 11-04-16 дагуу зохиогчийн дүгнэлтийг шинэчилсэн. |
| 2 | БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж, албан тоотоор ирүүлэх. | Барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч “Роуд дэвэлоупмент” ХХК-иас 2023 оны 04-р сарын 16 өдрийн 188/24 тоот албан тоотоор чанарын баталгаа ирүүлсэн. |
| 3 | Батлагдсан зураг төслийн дагуу гадна тохижилтыг хийж, хэрэгжүүлэх. | Төсвийн боломжоос шалтгаалан ажил гүйцэтгэл удааширсан ч одоогийн байдлаар гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байгаа ба 2024 оны 05 дугаар сарын 08-ны дотор дуусгах болно. |
| 4 | Шалнаас тааз хүртэлх цонхонд металл хамгаалалт хийх. | Шалнаас тааз хүртэлх цонхонд метаалл хамгаалалт хийсэн болно. |
| 5 | Дээврийн усны хаялга доош буулгах. | Дээврийн усны хаялга доош буулгасан болно. |
| 6 | Цахилгааны холбогдох шийдвэрүүд албажуулах. | Цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллага болох УБ төмөр замын |

| | | |
|---|---|---|
| | | эрчим хүч, ус түгээх 1-р ангитай 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Ашиглалт, үйлчилгээний гэрээ байгуулсан. |
| 7 | Дотор хялгасан болон хэвтээ хагарлуудад зохиогч, гүйцэтгэгч, ашиглагч нар тайлбар албан тоот ирүүлэх. | Барилгын зураг төслийн зохиогч “Уран үзэг” ХХК, барилгын ерөнхий гүйцэтгэгч “Роуд Дэвэлопмент” ХХК-иас тайлбар албан тоот ирүүлсэн.<br>Захиалагч “Глобал Сивик Шэйринг” ТГ-ын тайлбар албан бичиг хүргүүлсэн. |
| 8 | 1, 2-р давхарын тааз, шалгүй хонгил (цоожтой хаалга) тайлбар ирүүлэх (зохиогч, гүйцэтгэгч, ашиглагч). | Барилгын зураг төслийн зохиогч “Уран үзэг” ХХК, барилгын ерөнхий гүйцэтгэгч “Роуд Дэвэлопмент” ХХК-иас тайлбар албан тоот ирүүлсэн.<br>Захиалагч “Глобал Сивик Шэйринг” ТГ-ын тайлбар албан бичиг хүргүүлсэн. |

Үүрэг даалгаврын биелэлттэй холбоотой зургийг хавсралтаар хүргүүлэв.

ЗАХИРАЛ ______ Н.БАТДОРЖ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН

ҮҮРЭГ ДААЛГАВАР БИЕЛҮҮЛСЭН БАЙДЛЫН ЗУРАГ

**Үүрэг, даалгавар өгсөн**

Байгууллага: Хотын стандарт, хяналтын газар

Албан тушаал: Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга

Овог нэр: О.Оджаргал

Үүрэг даалгавар: Батлагдсан зураг төслийн дагуу гадна тохижилтыг хийж, хэрэгжүүлэх.

**Үүрэг даалгавар биелүүлсэн байдал:**

Байгууллага: Глобал Сивик Шэйринг ТББ

Үүрэг даалгаврын биелэлт:

1. Тусгай хэрэгцээт иргэний налуу замын хашлага суурилуулсан.
2. Шатны хажуугийн шавардлагын ажил гүйцэтгэгдсэн.
3. Шатны бариул, хашлага хийгдсэн.
4. Явган хүний замын хажуугийн хашлаганы модон багана суурилуулсан.
5. Ногоон байгууламжийн мод, бут сөөгийг 2023 онд тарьсан. Зүлэгжүүлэх талбай бэлдсэн.
6. Барилгын гэрэлтүүлэг, чимэглэл суурилуулсан, ажиллагааг шалгасан.

**Зураг**



Барилгын гадна гэрэлтүүлэг, чимэглэл.



Далангийн хашлаганы багана.



Налуу замын хашлага суурилуулахын өмнө.



Налуу замын хашлага суурилуулсны дараа.



Шатны бариул суурилуулахын өмнө.



Шатны бариул суурилуулсны дараа.



Шатны бариул суурилуулахын өмнө.



Шатны бариул суурилуулсны дараа.



Хашлага, тугны суурь суурилуулахын өмнө.



Хашлага, тугны суурь суурилуулсны дараа.



Аюултай хэсгүүдэд хашлага.



Налуу замын бариул.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
ҮҮРЭГ ДААЛГАВАР БИЕЛҮҮЛСЭН БАЙДЛЫН ЗУРАГ

**Үүрэг, даалгавар өгсөн**

Байгууллага: Хотын стандарт, хяналтын газар

Албан тушаал: Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга

Овог нэр: О.Оджаргал

Үүрэг даалгавар: Шалнаас тааз хүртэлх цонхонд металл хамгаалалт хийх.

**Үүрэг даалгавар биелүүлсэн байдал:**

Байгууллага: Глобал Сивик Шэйринг ТББ

Үүрэг даалгаврын биелэлт:

1. Шалнаас тааз хүртэлх цонхонд металл хамгаалалт хийсэн.

**Зураг**






БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
ҮҮРЭГ ДААЛГАВАР БИЕЛҮҮЛСЭН БАЙДЛЫН ЗУРАГ

**Үүрэг, даалгавар өгсөн**

Байгууллага: Хотын стандарт, хяналтын газар

Албан тушаал: Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга

Овог нэр: О.Оджаргал

Үүрэг даалгавар: Дээврийн усны хаялга доош буулгах.

**Үүрэг даалгавар биелүүлсэн байдал:**

Байгууллага: Глобал Сивик Шэйринг ТББ

Үүрэг даалгаврын биелэлт:

1. Дээврийн усны хаялга доош буулгасан.

**Зураг**






**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН ЭРЧИМ ХҮЧ, УС ХАНГАМЖИЙН НЭГДҮГЭЭР АНГИ**

16020 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
3-р хороо, Энгельсийн гудамж
Утас:(976-21) 24-47-20, Факс:(976-21) 24-47-36
И-мэйл: echvod1@ubtz.mn

2026.02.27 № 36/86

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАРТ

Тодорхойлолт хүргүүлэх тухай

"Глобал Сивик Шэйринг" төлөөлөгчийн газар нь манай Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн 1-р ангиас олгосон 2004 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн №103/2004 тоот техникийн нөхцөлийн дагуу 63кВа хүчин чадал бүхий КТП маягийн дэд станцыг 2004 онд угсарч цахилгаан эрчим хүчээр хангагдаж байсан.

Тус байгууллага нь 2022 онд "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төв"-ийн барилгын гадна цахилгаан хангамжаа манай №2022-84 тоот техникийн нөхцөлийн дагуу КТПН-250/10кВА маягийн дэд станц болгож хүчин чадлыг нэмэгдүүлж, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн ба манай байгууллагаас шинэ объект ашиглалтад хүлээн авах техникийн комисс ажиллаж №2022-8 тоот протокол үйлдсэн болно.Тус КТПН-250/10кВА дэд өртөөний гадна цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангахад Глобал Сивик Шэйринг төлөөлөгчийн газартай "Ашиглалт үйлчилгээний гэрээ" байгуулан ажиллаж байгаа ба манай байгууллагаас цахилгаан шугам, тоноглолын аюулгүй ажиллагаанд тогтмол үзлэг, шалгалт хийн засвар үйлчилгээний шаардлагыг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж ажиллаж байгаа болно.

Техникийн нөхцөл, комиссын протокол, гэрээний хуулбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГА Д.НАРАНБАЯР

1636260075

БАТЛАВ:

ЭРЧИМ ХҮЧ УС ХАНГАМЖИЙН 1-Р АНГИЙН
ДАРГА Ө.УУГАНЖАРГАЛ

# ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
**Дугаар № 2022-84**

2022-05-09 Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

| | | |
|---|---|---|
| 1.1 | Хүсэлтийн дугаар | Глобал Сивик Шэйринг ТГ-ын 2022-05-06-ны өдрийн 22/037 тоот бичгээр гаргасан хүсэлт |
| 1.2 | Хэрэглэгчийн нэр, РД | Глобал Сивик Шэйринг ТГ |
| 1.3 | Хэрэглэгчийн байршил | СХД 21-р хороо Аршаант өртөө Ухны ам 1-1 |
| 1.4 | Ажил үйлчилгээний Зориулалт | Аж Ахуй |
| 1.5 | Техникийн нөхцөл олгох үндэслэл | ТЭЗЗ-ийн 2022-05-09-ны хурлын шийдвэр |
| 1.6 | Техникийн нөхцлийн Ангилал | Хуучин хэрэглэгч 10 кВ |
| 1.7 | Тооцооны бүрэн чадал | 250 кВа /Хоёр зуун тавь /<br>Тоогоор Үсгээр |

**Хоёр. Холболтын цэг**

| | |
|---|---|
| 2.1 | КТП-63/10 дэд өртөөг КТПН-250/10 болгох |

**Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл**

| | |
|---|---|
| 3.1 | СХЗҮТ-ийн загварын туршилтанд орсон DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур байх |

**Дөрөв. Тусгай заалт**

| | |
|---|---|
| 4.1 | Салбар шугамын эхний болон төгсгөлийн анкер тулгуурыг төмөр бетон тулгуур болгох бөгөөд эхний анкерт агаарын шугамын вакум таслуур, төгсгөлийн анкерт хуурай салгуур тус тус суурилуулж газардуулах байгууламжид холбосон байх |
| 4.2 | Өөрийн хэрэгцээнд стандартын шаардлага, галын аюулгүй байдлыг хангасан КТПН-250/10 дэд өртөөг сууриллуулж газардуулах байгууламжид холбосон байх |
| 4.3 | Хангах сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж холболт авсан тулгуур, уг тулгуурын 2 талын тулгуурыг төмөр бетон тулгуур болгож газардуулга хийж холбосон байх. Мөн өөрийн цахилгаан хангамжийн 0,4 кВ агаарын шугамыг төмөр бетон тулгууртай бүрээстэй утас бүхий агаарын шугамаар шинэчлэн найдвартай ажиллагааг хангасан байх |
| 4.4 | УБТЗ-ЭХУХ-ийн 1-р ангийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд хийгдэх өргөтгөл, шинэчлэлийн ажлыг харьяа шугам сүлжээний хэсгээр гэрээ байгуулан гүйцэтгүүлэх |

*ЭХУХ-н I анги*
Байгууллагын нэр

*ШИНЭ ОБЪЕКТ АШИГЛАЛТАНД ХҮЛЭЭЖ АВАХ ТЕХНИКИЙН КОМИССЫН ПРОТОКОЛ*

№ 2022-08

2022 оны 06-р сарын 02

**Объектийн нэр төрөл:** *КТПН-250/10кВ*

**Захиалагчийн нэр:** *Глобал Сивик Шэйринг ТГ*

**Гүйцэтгэгчийн нэр:** *ЭЙ БИ ЖИ ЭНЕРГО ХХК*

**Шинээр холбогдох объектоос тэжээгдэх хэрэглэгчийн нэр:** *Глобал Сивик Шэйринг ТГ Аж ахуй*

**Шинээр холбогдох объектийн хаяг:** *Улаанбаатар хот СХД 21-р хороо Аршаант өртөө Ухны ам 1-1 тоот*

**Техникийн нөхцөлийн дугаар:** *№ 2022-84* *2022.05.09*

Техникийн комиссоос тавьсан шаардлага

**1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр:**

-
-

**2. Ашиглалтын чиглэлээр:**

-
-
-

**3. Шуурхай ажиллагааны чиглэлээр:**

-
-

**4. Борлуулалтын чиглэлээр:**

-
-

**Техникийн комиссын дарга:**

УБТЗ-ын ЭХУХ-н I ангийн ерөнхий инженер: [signature] Б.Доржсүрэн

Комиссын гишүүд:

Ашиглалтын инженер [signature] Д.Алтанзагас

Борлуулалтын инженер [signature] Г.Түмэннаст

Шуурхай үйлчилгээний инженер: [signature] М.Аззаяа

Реле хамгаалалтын инженер [signature] С.Ганбат

Хүлээн авсан: [signature] И. [signature]

ЭРЧИМ ХҮЧ УС ХАНГАМЖИЙН НЭГДҮГЭЭР АНГИ

Шинээр баригдсан шугам сүлжээ, дэд станцыг
хүчдэлд холбох зөвшөөрөл
№ 2022-08

1 **Хэрэглэгчийн нэр:** *Глобал Сивик Шэйринг ТГ*

2 **Хаяг:** Улаанбаатар хот СХД 21-р хороо Аршаант өртөө Ухны ам 1-1 тоот

3 **Холбогдох утасны дугаар:**

4 **Холбогдох объектийн байршил:** *Улаанбаатар хот СХД 21-р хороо Аршаант өртөө Ухны ам 1-1 тоот*

5 **Техникийн нөхцөлийн дугаар, огноо:** *№ 2022.84* *2022.05.09*

6 **Холбогдох цэг:** *КТПН-63/10кВ дэд өртөөг КТПН-250/10кВ болгон чадлыг нэмэгдүүлэх*

7 **Газар дээр нь шалгасан:** *2022.05.30*

8 **Шинээр баригдсан шугам сүлжээний бүдүүвч зурах:**




- Техникийн бичиг баримтууд, зураг бүдүүвч: Ажлын зураг
  Гүйцэтгэлийн бичиг баримт
  Туршилтын актууд

- АА-ны байдал: Хангагдсан.

Төлбөр тооцоо гүйцэтгэгдсэн байдал:

- Техникийн нөхцөлийн үнэ: 210000 төг
- Таслалт залгалтын хураамж: 52000 төг
- Гэрээ байгуулсан тухай тэмдэглэл:

........................................................................................................

........................................................................................................

........................................................................................................

БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧ, УС ХАНГАМЖИЙН НЭГДҮГЭЭР
АНГИЙН ДАРГА Д.НАРАНБАЯР

20.. он ... сар ... өдөр

БАТЛАВ:
ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ ТББ
ДАРГА Н.БАТДОРЖ

2026 он 2 сар 27 өдөр

# АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

## *Нэг. Гэрээний зорилго*

1.1 "Глобал Сивик Шэйринг" ТББ-н эзэмшлийн КТПН-250/10 дэд өртөөний цахилгаан хангамжийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангах, гэрээнд оролцогч талууд болох **УБТЗ-ын Эрчим хүч ус хангамжийн 1-р анги** /цаашид ашиглалт, үйлчилгээг гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас "Глобал Сивик Шэйринг" ТББ / цаашид хэрэглэгч гэх/-ийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжинд хийгдэх ажил үйлчилгээний зааг, журмыг тодотгох, хэрэглэгчийн эзэмшлийн тоноглолын ашиглалтын түвшинг хэвийн хэмжээнд байлгаж шугамын тасралтын тоог бууруулах, засвар үйлчилгээний ажлын аюулгүй байдлыг хангах, хоёр талын хүмүүсийн шуурхай ажиллагааг уялдуулан зохицуулах, сэлгэн залгалт хийх журам, талуудын сэлгэн залгалт хийх эрхийн хэм хэмжээг тодорхойлоход оршино.

## *Хоёр. Гэрээний хугацаа.*

2.1 Энэхүү гэрээ нь байгуулагдсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй ба гэрээг хоёр талаас хамтран хянаж дүгнэн, зохих өөрчлөлтүүдийг тусган, хугацааг сунгаж ажиллана. Шаардлагатай тохиолдолд гэрээг шинээр хийж болно.

## *Гурав. Цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн болон ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгэх зааг*

3.1 Ашиглалт, үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэгч талын өмчлөлийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг нь:

- *Тус ангиас олгосон "Шинээр баригдсан шугам сүлжээ, дэд станцыг хүчдэлд холбох зөвшөөрөл" №2022-08-д тусгагдсан цэгээр*

3.2 Ашиглалт, үйлчилгээ гүйцэтгэгч талын ажил үйлчилгээ явуулах зааг нь:

- *"Шинээр баригдсан шугам сүлжээ, дэд станцыг хүчдэлд холбох зөвшөөрөл"-д тусгасан цэгээс КТПН-250/10кВА дэд өртөөний 0.4кВ хуваарилах байгууламжийн ерөнхий таслуурын үл хөдлөх контактаар*

3.3 Шугам сүлжээ эзэмшигч талын ажил үйлчилгээ явуулах зааг нь:

- *КТПН-250/10кВА дэд өртөөний 0.4кВ хуваарилах байгууламжийн оруулгын эхний холболтоос дотогш.*

## *Дөрөв. Ашиглалт, ажил үйлчилгээ гүйцэтгэгчийн эрх, үүрэг.*

4.1 Ашиглалт, үйлчилгээг гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ явуулах эрхийнхээ хэмжээнд хэрэглэгчийн эзэмшлийн дэд өртөөний 10/0.4кВ-ын шугам сүлжээ, хуваарилах байгууламжуудад ашиглалтын үеийн үзлэг үйлчилгээг Цахилгаан байгууламжийн техник ашиглалтын дүрмийн дагуу графикаар гүйцэтгэх, шугам сүлжээнд гарсан гэмтлийг тодорхойлж, үндсэн тэжээлийн шугам сүлжээнээс тусгаарлаж, аваари саатал өргөжихөөс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

Гэмтэл саатлын улмаас үндсэн тэжээлийн шугамаас тусгаарлагдсан хэрэглэгчийн шугам сүлжээнд үүссэн үл тохирлын талаар эзэмшигч талд мэдэгдэж, шугам сүлжээг хэвийн ажиллагаанд оруулахад шаардагдах чиглэлээр дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. /шаардлагатай материал сэлбэг гэх мэт/

4.2 Шугам сүлжээ, дэд өртөөний тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг арилгах, солих, засварлах шаардлагатай болсон тохиолдолд хэрэглэгчийн эрх бүхий ажилтанд мэдэгдэж

холбогдох зардлыг шийдвэрлэсний үндсэн дээр засвар үйлчилгээг гүйцэтгэж тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулна.

4.3 Ашиглалт, үйлчилгээг гүйцэтгэгчийн эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмжийн ашиглалтад үзлэг шалгалт хийх, горим ажиллагааг хянах, мэргэжлийн зөвлөгөө өгөх эрхтэй

4.4 Ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгэгч нь мэргэжлийн хүн хүч, техникийн үйлчилгээ, шуурхай таслалт залгалтыг хэрэглэгчийн хүсэлтээр батлагдсан үнэлгээний дагуу төлбөртэйгээр гүйцэтгэх

4.5 Гэмтэл гарч сүлжээнээс тусгаарлагдсан хэрэглэгчийн өндөр хүчдлийн цахилгаан тоног төхөөрөмж, шугамыг туршилт, хэмжилт хийлгэсэн протоколыг үндэслэн залгах ба Лабораторын үнэлгээгээр ажлын хөлсийг тооцон авна.

4.6 Ашиглалт, үйлчилгээний гүйцэттэгч нь хэрэглэгчийн эзэмшлийн тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээ, сэлгэн залгалт болон энэхүү гэрээнд тусгагдсан бусад асуудалтай холбогдуулан хэрэглэгчид шаардлага тавих

4.7 Хэрэглэгчдийн өөрсдийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх захиалгыг ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгэгч нь хянаж үзэн зохих таслалтыг бүрэн хийж, хэрэглэгчийн эрх бүхий ажилд оруулагчид /ажил гүйцэтгэгч/ ажлын байрыг хүлээлгэн өгөх

4.8 Ашиглалт, үйлчилгээний гүйцэтгэгч нь жилд ..2.. удаа хүчдэл тасалж, хэрэглэгчийн КТПН-250/10кВА дэд станцад иж бүрэн үзлэг үйлчилгээ хийнэ.

## *Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг*

5.1 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн 0.4 кВ-н шугам сүлжээнд шинээр тоноглол нэмж залгах, хуучин тоноглол таслаж нүүлгэн шилжүүлэхээс бусад үзлэг, шуурхай ажиллагааны сэлгэн залгалтыг өөрийн эрх бүхий хүмүүсээр дамжуулан бие даан гүйцэтгэх

5.2 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжид сэлгэн залгалтыг зөв гүйцэтгэх, хэрэв буруу гүйцэтгэн осол гаргах, эд материалын хохирол учруулсан тохиолдолд үүссэн хариуцлагыг бүрэн хүлээх

5.3 Хангагчийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх үед хэрэглэгчийн эзэмшлийн тоноглолд таслалт, сэлгэн залгалт хийгдэх шаардлагатай бол уг таслалт, сэлгэн залгалтыг хэрэглэгчийн эрх бүхий хүн, ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгэгчийн эрх бүхий хүмүүс ажил үйлчилгээний зааг дотор хийж гүйцэтгэх

5.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн 0.4 кВ-н цахилгаан шугам сүлжээний, тоног төхөөрөмжийг бүрэн хариуцаж, үзлэг үйлчилгээ засвар шинэчлэлтийг Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу өөрийн хөрөнгөөр, хийж гүйцэтгэх.

5.5 Хэрэглэгчийн эрчим хүчний хангамж тасарвал хэрэглэгчийн шуурхай ажиллагаа явуулах эрх бүхий хүмүүс өөрийн эзэмшлийн 0.4 кВ-н, цахилгаан тоног төхөөрөмжид үзлэг хийх, үзлэгийн үр дүнг ашиглалт үйлчилгээний ажил гүйцэтгэгчийн эрх бүхий ажилтанд үнэн зөв мэдээлэх

5.6 Хангагчийн түгээх сүлжээнд гарсан аваари саатлаар хэрэглэгчийн эрчим хүчний хангамж тасарвал хэрэглэгчийн сэлгэн залгалт хийх эрх бүхий хүмүүс бэлтгэл тэжээлээр өөрийн эрчим хүчний хангамжийг сэргээх, үүнтэй холбоотой мэдээ мэдээллийг ашиглалт үйлчилгээний ажил гүйцэтгэгчийн эрх бүхий ажилтанд үнэн зөв өгөх

5.7 Хэрэглэгч өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоноглолд төлөвлөгөөт засвар хийхээр хангагчаас таслалт авах шаардлагатай бол засвар хийхээс 72 цагийн өмнө захиалгаа ашиглалт үйлчилгээ гүйцэтгэгчийн эрх бүхий ажилтанд өгөх

5.8 Ашиглалт, үйлчилгээг гүйцэтгэгчийн эрх бүхий хүмүүсийг өөрийн ашиглалтын хуваарилах байгууламж, дэд өртөөнд орох боломжийг хоногийн 24 цагаар хангах.

5.10 Хэрэглэгчийн эзэмшлийн тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээ, сэлгэн залгалт болон энэхүү гэрээнд тусгагдсан бусад асуудалтай холбогдуулан тавьсан ашиглалт, шуурхай үйлчилгээ гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэх

5.11 Хэрэглэгч нь хангагчийн түгээх сүлжээнд холбогддог, сүлжээний горим ажиллагаанд нөлөөлдөг өөрийн эзэмшлийн кабель шугам, тоноглолуудыг байнгын ажлын бэлэн байдалд байлгах гэмтсэн тохиолдолд яаралтай засуулах арга хэмжээ авах

5.13 Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн автоматикуудын тавил, хугацааны барил, гал хамгаалагчуудын тавил нь тэжээлийн төвтэй зохицуулагдсан байх

5.14 Хэрэглэгчийн шугам тоноглолд ашиглалтын явцад гарсан гэмтлийн улмаас шугам фидерийн аваарийн тасралт гарвал хариуцлагыг хүлээх

5.15 Хэрэглэгч тал нь Аваарийн болон бусад шуурхай сэлгэн залгалтыг төлбөргүйгээр гүйцэтгүүлэх.

***Зургаа. Төлбөр тооцоо***

6.1 Ашиглагч үйлчилгээний гэрээ байгуулагч талууд гэрээгээр гүйцэтгэх ажлын хөлсийг УБТЗ ХНН-н ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН БАТАЛСАН "ЦАХИЛГААНААР ХАНГАХ ТҮГЭЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ"-ын дагуу жилд 1 удаа 675.000 төгрөгөөр тооцож хэрэглэгч тал гүйцэтгэгчийн **Хаан** банкны 5039008726 дансанд шилжүүлнэ.

6.2 Энэхүү гэрээг талууд баталж хүчин төгөлдөр мөрдөгдөх өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд Ашиглалт үйлчилгээний гэрээний дагуу гүйцэтгэх ажлын төлбөрт өөрчлөлт орохгүй ба гэрээний хугацаа дуусгавар болсон өдөр талууд гэрээг дүгнэж, цаашид сунгах эсэхээ шийдвэрлэнэ. Гэрээний сунгалт хийгдсэн нөхцөлд төлбөрийг "ЦАХИЛГААНААР ХАНГАХ ТҮГЭЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ"-т өөрчлөлт орсон нөхцөлөөр дахин байгуулна.

6.3 Хэрэглэгчийн шугам сүлжээнд гарсан аваари саатлыг устгаж, шугам сүлжээг хэвийн ажиллагаанд оруулах ажлын төлбөр ажилбарын цар хүрээгээр тодорхойлогдох ба ажил гүйцэтгэсэн үнэлгээний дагуу нэхэмжилнэ.

***Долоо. Гэрээний хариуцлага***

7.1 Талууд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас гарсан хохирлыг буруутай тал хариуцна.

7.2 Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн гэмтлээс шалтгаалан хангагчийн шугам тоноглолд тасралт гэмтэл гарснаас үүдсэн хохирлыг хэрэглэгч тал хариуцна.

7.3 Цахилгаан эрчим хүчний тасалдал, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс болон буруу сэлгэн залгалтаас үүдсэн хохирлыг хоёр талаас комисс гарган тогтоож, тав хоногийн дотор хамтарсан акт үйлдэн, шалтгааныг тогтооно.

***Найм. Гэрээний нэмэлт өөрчлөлт***

.................................................................................................................................
.................................................................................................................................
.................................................................................................................................

**Гэрээ байгуулсан:**

Хангагчийг төлөөлж:
ЭХУХ-1 ангийн Ашиглалтын инженер
..................................... Б.Наранбаяр
Утас: 86114732
ЭХУХ-1 анги Мандал ЦШС-ний хэсгийн мастер :...................................А.Анхбаяр
Утас: 86114726
20... он ... сар ... өдөр

Хэрэглэгчийг төлөөлж:
Глобал Сивик Шэйринг ХХК захирал
..................................... Н.Батдорж
Утас: 90116046
2026 он 02 сар 27 өдөр

**БАТЛАВ:**
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ ХНН ЭРЧИМ ХҮЧ УС ХАНГАМЖИЙН 1-Р АНГИЙН ДАРГА:
Д.НАРАНБАЯР

**БАТЛАВ:**
ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ ТГ-ИЙН ЗАХИРАЛ:
Н.БАТДОРЖ

**АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ /10кВ/**

**2026** оны **02**-р сарын **27**-ны өдөр    Гэрээний дугаар **4.01.091**    Хэрэглэгчийн код **545300876**

Нэг талаас Улаанбаатар төмөр зам ХНН-ийн Эрчим хүч, ус хангамжийн нэгдүгээр анги /цаашид "Хангагч" гэх/, түүнийг төлөөлж Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн хэсгийн борлуулалтын инженер албан тушаалтай **Эрхэмбаяр** овогтой **Жавхлан**, нөгөө талаас **9093907** регистрийн дугаартай **Глобал сивик шэйринг ТГ**-ийн захирал **Нарангэрэл** овогтой **Батдорж** /цаашид "Хэрэглэгч"/ нар "Монгол улсын Иргэний хууль", "Эрчим хүчний тухай хууль", "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, ""Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм" болон бусад хууль, тогтоомжийг удирдлага болгон дор дурдсан нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг **2029** оны **02** дугаар сарын **27**-ны өдөр хүртэл /гурван жилээр/ хугацаагаар байгуулав.

## НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Талууд энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдсон гэрээний нөхцөлд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын "Иргэний хууль", "Эрчим хүчний тухай хууль", "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм", "Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм" "Галын аюулгүй байдлын тухай хууль" Монгол Улсын Стандарт "Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага" MNS:5872; MNS:2008 бусад хууль, тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.

1.2 УБТЗ ХНН –ийн Эрчим хүч ус хангамжийн 1-р ангитай "Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ" байгуулах хэрэглэгч нь шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлтэй, хэрэглэгчийн мэдээлэлийн сангийн бүрдүүлэлтийг хийлгэсэн байна.

1.3 Энэхүү гэрээг үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчтэй байгуулна. Тус үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч гэрээ байгуулах боломжгүй тохиолдолд нотариатаар баталгаажсан итгэмжлэлийн үндсэн дээр хамтран хариуцагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Харин үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч, түр эзэмшигчтэй байгуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр давхар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

1.4 Хамтран хариуцагч, түрээслэгчтэй гэрээ байгуулсан тохиолдолд төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, түрээслэгч, эзэмшигч нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

## ХОЁР: ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 5 дугаар зүйл, Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд тус тус заасанаас гадна дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

2.1 Тарифын ангилал, төлбөр төлөх хэлбэр, хангагчтай харьцдаг банкуудаас өөрийн харьцдаг банкийг сонгож гэрээнд тусгах; /и-биллинг үйлчилгээ, интернэт банкны аппликейшинд хэрэглэгчийн кодыг холбох/

2.2 Хангагчийн үйл ажиллагаатай холбоотой болон өөрийн санал, хүсэлт, гомдол, төлбөр тооцоотой холбоотой асуудал, гэмтэл тасралт болон бусад мэдээллийг хангагчийн 7755-5500, 21-245722 утсаар авах болон Хэрэглэгчдэд үйлчлэх төвд өөрийн биеэр санал, хүсэлт гомдлоо гаргаж болно. 1800-1949 утсанд талархал илэрхийлж болно.

2.3 Эзэмшлийн заагаар тодорхойлсон өөрийн цахилгаан шугам сүлжээ, цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээг бүрэн хариуцаж хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах, шаардлагатай тохиолдолд төлбөртэй үйлчилгээ авах;

2.4 Цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоонд илүү болон дутуу төлбөр төлсөн, төлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахилгаан эрчим хүчний бичилтийн залруулга хийлгэх, дараа сарын төлбөрт шилжүүлэн тооцох;

2.5 Өөрийн эзэмшлийн шит, шугам тоноглолтой бол хангагч талаас урьдчилан зөвлөмж авч автомат сэлгэн залгагч суурилуулж мөн хүчдэл өндөрсөн гарах боломжийг хязгаарласан байна.

2.6 Шугам тоноглолдоо автомат сэлгэн залгагч төхөөрөмж, мөн аваарын нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр суурилуулах бол хангагчид заавал мэдэгдэх;

2.7 Хэрэглэгч өөрийн эзэмшлийн дэд станц, шугам сүлжээ, тоноглолд ААД, ТАД –ын дагуу ашиглалт үйлчилгээ, засварын ажлыг хийх бөгөөд эдгээр шугам тоноглолын ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан мэргэжлийн ажилтныг томилон ажиллуулах, эсвэл мэргэжлийн ажилтан, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх;

2.8 Хэрэглэгч өөрийн биеэ даасан 6, 10кВ-ын өндөр хүчдлийн шугам тоноглолын найдвартай ажиллагааг хангах зорилгоор хангагч байгууллагатай "ЦАХИЛГААНЫ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ"-г байгуулах;

2.9 Цахилгаан эрчим хүчээр хязгаарлуулсан зөрчлийг арилгасан бол цахилгаан эрчим хүчээ сэргээлгэх хүсэлтээ гаргах;

2.10 Цахилгаан эрчим хүчний 3 сар болон түүнээс дээш хугацаанд төлөгдөөгүй төлбөрөө төлөхдөө нийт дүнгийн 30 хувийг урьдчилан төлсөн тохиолдолд " Авлага хэсэгчлэн барагдуулах гэрээ" байгуулах хүсэлт гаргах;

2.11 Хэрэглэгч хангагчаас олгосон техникийн нөхцөлийн дагуу цахилгаан шугам сүлжээ, дэд станц, горим схем, зориулалт, хүчин чадлыг өөрчилж, нэмэгдүүлэхгүй байх, өөрчлөлт оруулах тохиолдолд хангагчаас зөвшөөрөл авах; Энэ тухай хангагчид мэдэгдээгүй тохиолдолд үүссэн хохирлыг хангагч хариуцахгүй;

2.12 Эзэмшлийн заагаар тодорхойлсон өөрийн цахилгаан шугам сүлжээ, дэд станц, дотор холболт, цахилгаан

хариуцах, цахилгаан шугам сүлжээ, дэд станц, тоног төхөөрөмжид аюул осол гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэх;

2.13 Өөрийн эзэмшлийн дэд станц, шитний бүрэн бүтэн байдал, галын аюулгүй байдлыг бүрэн хариуцах ба шитний газардуулгыг тогтмол хугацаанд мэргэжлийн байгууллагаар туршуулан, газардуулгын актыг хангагч байгууллагад өгөх;

2.14 Өөрийн эзэмшлийн шугам тоноглолд хэт хүчдэлийн хамгаалалт, гүйдэл ихсэлтийн, хэт ачааллын, хүчдэл ихсэлт бууралтын, фаз 0 тасралт, фазын дараалал алдагдлаас сэргийлсэн тоноглол болон хэрэглэгчид ашиглагдах цахилгаан тоног төхөөрөмжийн онцлогоос шалтгаалсан реле хамгаалалтаар тоноглож хамгаалах;

2.15 Хэрэглэгч нь сард захиалсан эрчим хүчнээс +2 хувиас илүү буюу дутуу ЦЭХ хэрэглэсэн тохиолдолд /захиалга хэрэглээний зөрүүг/ "Импортын цахилгаан эрчим хүчний графикийн хазайлтыг тооцох журмын" дагуу хэрэглээний хазайлтын төлбөрийг тооцно.

2.16 Хэрэглэгч нь "Импортын цахилгаан эрчим хүчний графикийн хазайлтын журам"-д заасны дагуу өмнөх сарын 15-ны дотор дараа сарын хэрэглээний захиалгаа тодотгож өгөх;

2.17 Хэрэглэгч нь хэрэглээний захиалгад тодотгол хийгээгүй, хийсэн боловч өмнөх сарын 15-ны өдрөөс хойш ирүүлсэн тохиолдолд тодотгох боломжгүй;

2.18 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний хуурмаг хэрэглээнээс хамааруулж ЭХЗХ-ны Зохицуулагчийн Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу чадлын итгэлцүүр (COS$\varphi$)-ээс хамаарсан нэмэлт төлбөр тооцно.

2.19 Хэрэглэгч нь өөрийн тухай мэдээлэл /нүүн шилжсэн, утасны дугаар, и-мэйл хаяг, гэх мэт/ хангагчид үнэн зөв өгөх, мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдол бүрд цаг тухайд нь мэдэгдэн өөрчлөлт оруулж байх;

2.20 Хангагчийн эрх бүхий ажилтныг тоолуурын заалт авах болон бусад ажлаар өөрийн эзэмшлийн хашаа, үл хөдлөх хөрөнгөнд орох, үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй байх, дэд станц, цахилгаан шугам, тоноглол тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, шитний болон шитэнд нэвтрэх хаалгануудын түлхүүрийг хоногийн 24 цагаар байнгын бэлэн байдалд байлгах;

2.21 Хэрэглэгч нь нарийн мэдрэмжтэй тоног төхөөрөмж хэрэглэж байгаа бол гүйдэл, хүчдэлийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмж тавьсан байх;

2.22 Эрх бүхий байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, зөөж шилжүүлэхгүй байх;

2.23 Цахилгаан эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх, төлбөрөө хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд нэхэмжлэл хүлээн авснаас хойш 3 өдрийн дотор Хэрэглэгчдэд үйлчлэх төвд ирж асуудлаа шийдвэрлүүлэх;

2.24 Нөхөн тооцооны төлбөр, алданги, цахилгаан хэрэглээг түдгэлзүүлсэн, цахилгаан хангамжийг сэргээх, бусад үйлчилгээний төлбөр сануулах, түдгэлзүүлэх, болон шүүхэд шилжүүлэх мэдэгдэл хүргэсний төлбөр хураамжуудыг зохих журмын дагуу төлөх;

2.25 Өөрийн эзэмшлийн дэд станц, шит, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүй гуравдагч этгээдийг цахилгаан эрчим хүчинд холбохгүй байх, суурилагдсан хүчин чадал, хийц, зориулалт, байрлалыг нь дур мэдэн өөрчлөх, өргөтгөхгүй байх, суурилагдсан чадлаас хэтэрсэн тоноглол тавьж чадлыг хэтрүүлэхгүй байх;

2.26 3-р зэрэглэлийн /хэрэглэгч/ шугам тоноглолоос тэжээгдэж байгаа хэрэглэгч цахилгаанаар халаалтаа бүрэн шийдвэрлэсэн тохиолдолд заавал нэмэлт нөөц тэжээлийн эх үүсвэр суурилуулсан байх;

2.27 Гэрээний хугацаа дуусах, өөрчлөлт орох, цикл өөрчлөгдсөн тохиолдолд хангагчийн мэдэгдсэнээр хэрэглэгч нь Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирж гэрээний өөрчлөлтийг харилцан тохиролцож гэрээнд тусгуулах;

2.28 Өөрийн эзэмшлийн дэд станц, шугам сүлжээ, тоноглолоос тэжээгдэж буй кабель шугам залгаасгүй байх ба техникийн шаардлагын дагуу газарт булсан байх;

## ГУРАВ: ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 9 дүгээр зүйл, Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч - Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд тус тус зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:**

3.1 Цахилгаан эрчим хүчний шугам, сүлжээний хамгаалалтын зурвас дотор хангагчийн зөвшөөрөлгүй барилга, байшин, хашаа, гэр болон бусад объектыг байршуулсан хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахгүй бөгөөд гэрээ байгуулахаас татгалзах;

3.2 Хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хэрэглэгчийн дэд станц, шугам шугам сүлжээ, 0.4кВ-н шитнээс бусад хэрэглэгчийн холбох;

3.3 Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцох, нөхөн тооцооны төлбөрийг нэхэмжлэх;

3.4 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөр, нэмэлт төлбөр, үйлчилгээний хураамж, нөхөн тооцооны төлбөрөө төлөөгүй, хангагчийн шаардлага, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний заалтыг биелүүлээгүй бол төлбөрөө төлөхийг албан ёсоор шаардах, мэдэгдэл хүргэх, түдгэлзүүлэх;

3.5 Онцгой байдлын ерөнхий газар, Газрын алба, Нийслэл дүүргийн тамгын газар, бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг үндэслэн зөрчилтэй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлэх; /Энэ тохиолдолд 3 хоногийн өмнө мэдэгдэл өгөх/;

3.6 Хангагч Эрчим хүчний тухай хуулийн 32 дахь заалтын үндэслэн Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх;

3.7 Хангагч нь зайлшгүй шалтгааны улмаас хэрэглэгчийн бичилт, төлбөр тооцоо хийх циклийг өөрчлөх;

3.8 Хэрэглэгч эрчим хүчний шугам сүлжээ, дэд станц, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах, хэрэглэгч нь уг эвдрэл гэмтлийг засах арга хэмжээг авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй;

3.9 Хэрэглэгч нь цахилгаанаар түдгэлзүүлсэн шалтгааныг хүлээн зөвшөөрч шийдвэрлэн зөрчил устгах арга хэмжээг авч, үйлчилгээний төлбөр хураамжуудыг урьдчилан төлөгдсөн бол Хэрэглэгчийн цахилгаан хангамжийг холбогдох журмын дагуу стандартад заасан хугацаанд сэргээх;

3.10 Хангагч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийг гэмтээж шатаасан бол гэмтэл тогтоосон актыг үндэслэн өөрийн хөрөнгөөр сэргээн засварлаж өгөх;

## ДӨРӨВ: ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

4.1 Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтын тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажсан, хангагчийн ажилтны битүүмжилсэн тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуурын заалтыг баримтлан хийнэ.

4.2 Цахилгааны төлбөр тооцооны хэмжих хэрэглэлийн хэвийн ажиллагаа алдагдсан болон цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн болох нь тогтоогдвол Цахилгаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 5 дахь хэсгийн холбогдох заалтуудыг үндэслэн нөхөн төлбөр төлбөр тооцно.

4.2.1 Хэрэглэгчийн тоолуурын заалт авах үед тухай тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байгааг хангагчийн ажилтан илрүүлсэн бол тооцооны хэмжих хэрэглэлийн гэмтэлд хэрэглэгчийн буруутай үйлдэл нөлөөлсөн эсэхийг тогтоож тоолуур тооцооны хэмжих хэрэглэлд үзлэг хийсэн акт үйлдэнэ.

4.2.2 Тооцооны хэмжих хэрэглэлийн хэвийн ажиллагаа алдагдсанд хэрэглэгч буруутай буюу цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн болох нь тогтоогдвол цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 7.5 дугаар заалт, Тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийн 5.1.4, 5.1.5 дугаар заалтуудыг тус тус үндэслэн хэрэглээг тооцно.

4.3 Тоолуур тооцооны хэрэглэлийг хангагч хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина. Эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформаторын (ачааллын болон хоосон явалтын) алдагдлыг шугам сүлжээг эзэмшигч хүлээнэ;

4.4 Төлбөрийн нэхэмжлэлд цахилгаан эрчим хүчний төлбөр тусгагдахаас гадна нөхөн тооцооны төлбөр, хугацаа хэтрүүлсний алданги, төлбөрт үйлчилгээ үзүүлсэн бол үйлчилгээний төлбөр бусад нэмэлт төлбөрүүд тусгагдсан байна;

4.5 Төлбөрийн нэхэмжлэлд цахилгаан эрчим хүчний нэхэмжлэл тусгахаас гадна шугам болон трансформатор дахь алдагдал, чадлын итгэлцүүр ($COS\varphi$)-ээсхамааруулж тооцсон төлбөр, графикийн хазайлтаас тооцсон төлбөр, нөхөн тооцоооны төлбөр, хугацаа хэтэрүүлсний алданги, дараа төлбөрт үйлчилгээ үзүүлсэн бол үйлчилгээний төлбөрт хураамж, нэмэлт төлбөр, баримтны үнэ зэрэг бусад төлбөр тусгагдсан байна.

4.6 Хэрэглэгч нь хангагчийн төлбөрийн нэхэмжлэл банканд хүргэгдсэнээс гэрээнд заасан төлбөрийг нэхэмжилсэн төлбөрийг төлөх бөгөөд энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.5 хүртэлх хувиар алданги төлнө;

4.7 Тухайн байр, хашаа, газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч иргэн нүүхдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тооцоогоо хийж дуусган энэ тухай тодорхойлолтыг хангагчаас авсан байна. Энэ тодорхойлолтыг тухайн хуулийн этгээд шаардаж авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй тохиолдолд шинээр өмчлөгч, эзэмшигч эрчим хүчний өрийг хариуцна;

4.8 Хангагчтай гэрээ байгуулсан үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч нь нас барсан, нүүн шилжихдээ цахилгаан эрчим хүчний төлбөрөө төлөөгүй тохиолдолд энэхүү гэрээний 1.3, 1.4-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч төлбөр тооцоо болон гэрээтэй холбоотой асуудлыг хариуцна.

4.9 Хэрэглэгч цахилгаан сүлжээнээс салгуулах хүсэлт гаргахад тоолуурын заалтыг сүүлийн удаа авснаас хойш таслалт хийх өдөр хүртэлх цахилгааны төлбөрийн зөрүү болон үйлчилгээний төлбөрийг төлнө.

4.10 Улирлын шинж чанартай болон түр холбогдох хэрэглэгчийн хувьд цахилгаан эрчим хүчний урьдчилгаа төлбөр төлж холболт хийлгэх;

4.11 Хангагчийн ажилтан хэрэглэгчийн тоолуурын заалтыг авах үед хэрэглэгч эзгүй болон бусад шалтгаанаар заалт аваагүй тохиолдолд тухайн сарын хэрэглээг сүүлийн 3 сарын дунджаар тооцох ба 2 сар дараалан заалт авах нөхцөлөөр хангаагүй бол цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ;

4.12 Хэрэглэгчдэд төлбөрийн мэдээллийг мессежээр сар бүр 1 удаа илгээх бөгөөд цахилгаан эрчим хүчний өр төлбөртэй холбоотой 2 дахь мессежийн төлбөрийг хэрэглэгч хариуцна.

4.13 Цахилгаан зарцуулалтын төлбөрийн тооцоог хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос баталсан үнэ, тарифыг мөрдөнө.

4.14 Төлбөрт үйлчилгээний төлбөрийг хангагч байгууллагад мөрдөгдөж байгаа үнэ тарифын дагуу төлөх;

4.15 Хангагч "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Эрчим хүч ус хангамжийн нэгдүгээр анги нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байгууллага биш бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татварын баримт, буцаалт олгохгүй болно.

## ТАВ: ТООЦООНЫ ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1 Хэрэглэгчийн хэрэглээг тооцож байгаа хангагчийн өмчлөлийн тоолуур, тооцооны хэмжих хэрэгсэл, ухаалаг тоолуурын цуглуулагч, цахилгааны самбарын бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна. Хэрэв уг тоолуур тооцооны хэмжих хэрэгсэл алдагдсан, хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж гэмтсэн тохиолдолд хэрэглэгч гарах зардлыг хариуцна.

5.2 Тооцооны хэмжих хэрэглэлийг хангагч байгууллага эсвэл СХЗГ-н итгэмжлэгдсэн лабораториар баталгаажуулах ба баталгаажуулахтай холбоотой гарах зардлыг хэрэглэгч хариуцна;

5.3 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэглэлийг хугацаат баталгаажуулалт болон хэрэглэгчийн хүсэлтээр шалгаж баталгаажуулах явцад ороолсон, гэмтээсэн нь хэрэглэгчийн буруугаас шалтгаалсан нь

лабораторийн дүгнэлтээр тогтоогдсон бол энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж, хангагчийн эрх бүхий ажилтан акт үйлдэн, тооцооны хэмжих хэрэглэл гэмтэлтэй байсан хугацаанд дутуу тооцсон цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцооны төлбөр, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилнэ.

5.4 Хэрэглэгчийн тоолуур, тооцооны хэмжих хэрэглэлийн битүүмжлэл алдагдсан, дутуу тоолсон, эвдэрсэн, гацсан тохиолдолд дутуу тооцсон эрчим хүчийг нөхөж тооцно.

5.5 Тооцооны хэмжих хэрэгсэл нь хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөлийн дагуу Монгол улсын "Хэмжилзүйн тухай хууль"-д заасны дагуу стандарт хэмжил зүйн газарт загварын туршилтанд орж баталгаажсан Монгол улсад ашиглагдаж буй цахилгааны бүрэн-электрон, ухаалаг тоолуур, хэмжүүрийн трансформаторууд байна. Тэдгээрийн холболтын хэлхээ нь тусдаа хайрцаг щитэнд байрласан байх ба Хангагчийн эрх бүхий ажилтны битүүмжилсэн лацтай байна.

5.6 Дэд станц, шит, цахилгаан тоног төхөөрөмж, цахилгааны самбар, цахилгаан хэрэгсэл нь хөндийрүүлэг гэмтэхэд хүчдэлтэй болох металл хийц хэсгийг газардуулсан байх ёстой. Газардуулгын эсэргүүцэл нь 4 Ом-с ихгүй байх ба хэмжилтийг жил бүр хийлгэж актаар баталгаажуулсан байх.

5.7 Тоолуурын хайрцаг буюу щитийг 1.4-1.7 метрийн өндөрт хөдөлгөөнгүй байрлуулах бөгөөд найдвартай газардуулсан (4 Омоос бага) байх шаардлагатай. Газардуулга, хэт хүчдлийн хамгаалалтын хэмжилтыг жил бүрийн аянгын улиралын өмнө эрх бүхий хуулийн этгээдээр хэмжүүлж баталгаажуулсан байна.

5.8 Тооцооны хэмжих хэрэглэлийг тэжээж байгаа хэмжүүрийн трансформаторыг солих, тооцооны тоолуурыг салгах, тавих ажлыг зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Тооцооны тоолуурыг сүлжээнээс салгах, холбох үед хэрэглэгчийн төлөөлөгчийг байлцуулна.

## ЗУРГАА: ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР

6.1 Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 5.1 дүгээр заалтын дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, гэр, байр, граж, агуулахын цахилгаан сүлжээний дотоод холболт, гэр байшингийн оруулгын кабель, давхрын шитний монтаж болон цахилгаан хэрэгслийн ашиглалт, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх /гал түймэр эсэргүүцэх тоноглолоор тоноглох/ шаардлагуудыг бүрэн хариуцах үүрэгтэй.

6.2 Хэрэглэгч цахилгааны тэжээлийн утсыг өөрийн ачааллалдаа тохируулан хэт ачаалагдахгүй байх хөндлөн огтлолын талбайтай утсыг сонгож авна. Хангагчаас техникийн нөхцөл олгосон бол техникийн нөхцөлд заасан хөндлөн огтлол бүхий дамжуулагчийн сонгоно.

6.3 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, кабель утас, цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дотор монтажны холболтын галын аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэн гарах хохирлыг хангагч байгууллага хариуцахгүй.

## ДОЛОО: ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

7.1 Цахилгаан эрчим хүчний тасалдал, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс болж хангагчтай гэрээтэй хэрэглэгчид хохирол учруулсан тохиолдолд 24 цагийн дотор хэрэглэгч, хангагчид мэдэгдэж хамтарсан акт үйлдэн гаргасан шийдвэрийг үндэслэн хохирлыг буруутай тал төлнө.

7.2 Цахилгаан эрчим хүчний тасалдлаас учирсан хохирлыг дор дурдсан тохиолдолд хангагч хариуцахгүй.

- 7.2.1 Байгалийн гэнэтийн аюул /аянга, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэт/ тохиолдсон
- 7.2.2 Хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамжийг түдгэлзүүлсэн.
- 7.2.3 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 29.1.2, 32 дугаар зүйлд заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан хангамжийг түдгэлзүүлсэн.
- 7.2.4 Хэрэглэгчийн цахилгаан дамжуулах шугамыг гуравдагч этгээд гэмтээж эрчим хүчээр тасалдуулсан.
- 7.2.5 Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тасралт, саатал, гэмтэл гарснаас цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн.
- 7.2.6 Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон 3 дахь этгээдийн үйл ажиллагаанаас шалтгаалсан осол, аваарь, саатал гарсан тохиолдолд.

7.3 Хэрэглэгч өөрийн буруутай үйлдэл мөн өөрийн өмчлөлийн буюу эзэмшлийн гэрийн тэжээвэр амьтдыг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хангагчийн ажилтнуудад хохирол учруулсан бол холбогдох хууль дүрмийн дагуу хохирлыг төлнө.

7.4 Зар, мэдээлэл, албан бичгийг хэрэглэгчийн гэрээнд заасан хаяг, байршил, и-мэйл хаягаар явуулах эсвэл утасны дугаарт мессежээр хүргүүлэх бөгөөд хаяг, байршил, и-мэйл хаяг, холбоо барих утасны дугаар өөрчлөгдсөнийг хангагч талд албан ёсоор мэдэгдээгүйгээс /мессеж хүргэх үед гар утасны оператор компаниудын үйл ажиллагаа саатсан, хэрэглэгчийн утас унтарсан, сүлжээгүй байснаас мэдэгдэл мессежээр очоогүй/ гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй.

## НАЙМ: МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Хангагч хэрэглэгч талуудын хооронд гарсан цахилгаан эрчим хүчний хангамж, хэрэглээ, төлбөр тооцоотой холбогдсон маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8.2 Хэрэв харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй бол Эрчим Хүчний Зохицуулах Хороо, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болон мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагад маргаантай асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

8.3 Талууд дээрх байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

## ЕС: ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ДҮГНЭХ, ЦУЦЛАХ

9.1 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журамд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө шинэчлэн байгуулна.

9.2 Хангагч, хэрэглэгч талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийг бичгээр үйлдэн гэрээнд тусгана.

9.3 Хангагч, хэрэглэгчийн хоорондын эзэмшлийн заагийг тодорхойлсон хавсралтыг техникийн нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд талууд заавал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

9.4 НЭГ ДҮГЭЭР хавсралт "Хэрэглэгчийн гэрээний үндэслэл", ХОЁР ДУГААР хавсралт хэрэглэгчийн авах цахилгаан эрчим хүчний хэмжээ" ГУРАВ ДУГААР ХАВСРАЛТ "Хангагч, хэрэглэгчийн цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг" хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

9.5 Гэрээний хавсралтуудад шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хангагч утсаар болон бичгээр мэдэгдэх бөгөөд заасан хугацаанд хэрэглэгч гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

9.6 Хэрэглэгч гэрээний хугацаа дуусахаас өмнө нэг сарын өмнө Хэрэглэгчдэд үйлчлэх төв дээр ирж хангагчтай тооцоо нийлж гэрээ дүгнэсэн протокол үйлдэнэ.

9.7 Гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Талуудад хадгалагдсан хувь тус бүр нь нэгэн адил хүчин төгөлдөр байна.

9.8 ЦЭХ-р хангах гэрээг хуульд заасанаас гадна дараах нөхцөлд хугацаанаас нь өмнө цуцална.

 9.8.1 Аль нэг талын санаачилгаар

 9.8.2 Хэрэглэгч гэрээний үүргээ зөрчсөн, хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол

9.9 Гэрээ цуцлагдсан хэрэглэгчийн тоолуур тооцооны хэрэгсэл, кабель, шугам сүлжээг хүчдэлээс салган, хэрэглэгчийг дахин шугам сүлжээнд холбогдох боломжийг хязгаарласан техникийн арга хэмжээг авна.

9.10 Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй болон хэрэглэгч төлбөрийн зөрчилгүй байвал гэрээг анх заасан хугацаагаар гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн дахин нэг удаа мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Хангагчийг төлөөлж:**

УБТЗ ХНН Эрчим хүч ус хангамжийн 1-р анги

Хэргэлэгчдэд үйлчлэх төвийн хэсгийн инженер

Эрхэмбаяр овогтой Жавхлан

/ / гарын үсэг

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн гэрээний техникч

Энхболд овогтой Чингэрэл

/ / гарын үсэг

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 3-р хороо, Энгельсийн гудамж

Утас: 77555500, 21245722
Вэб : www.echvod.mn
И-мэйл: echvod1.hut.geree@gmail.com

**Хэрэглэгчийг төлөөлж :**

Глобал сивик шэйринг ТГ-ийн захирал:

Нарангэрэл овогтой Батдорж

/ гарын үсэг

**Хамтран хариуцагч**

................................овогтой............................

/ / гарын үсэг

**Хаяг:** УБ, СХД 21-р хороо, Ухны ам 1-1

**Утас:** 90116046, 80044088

И-мэйл:

### ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

Гэрээг ....... оны ..... сарын ...... өдөр хүртэл сунгав.

**Хангагчийг төлөөлж:**

УБТЗ ХНН Эрчим хүч ус хангамжийн 1-р анги

......................................... цахилгаан шугам сүлжээний хэсгийн инженер /мастер/

................................овогтой............................

/ / гарын үсэг

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн гэрээний техникч

................................овогтой............................

/ / гарын үсэг

**Хэрэглэгчийг төлөөлж :**

................................овогтой............................

/ / гарын үсэг

**Хамтран хариуцагч**

................................овогтой............................

/ / гарын үсэг

**Түрээслэгч**

................................овогтой............................

/ / гарын үсэг

20.....оны........сарын.........өдөр

## ХАВСРАЛТ №1: ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭНИЙ ҮНДЭС МЭДЭЭЛЭЛ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | 1. Хэрэглэгчийн техникийн үзүүлэлт | | | Өгөгдөл |
| | 1.1 Техникийн нөхцлийн № | | | 2022-84 |
| | 1.2 Суурилагдсан чадал /кВт/ зөвшөөрөгдөх гүйдэл | | | 250 кВа |
| | 1.3 Хэрэглэгчийн зэрэглэл | | | III |
| | 1.4 Хүчдэлийн түвшин /кВ/ | | | 10/0,4 кВ |
| | 1.5 Хэрэглэгчийн ангилал | | | ГААНБ |
| | Харъяа обьектын нэр | Тоолуурын марк | Тоолуурын № | Бат.ж.сан огноо |
| | Харьяа объектын нэр | Г.Тр-н марк | Г.Тр-н номер | Үржих коэффициент |
| 2 | 2. Цахилгаан эрчим хүчний төлбөр, тооцоо | | | |
| | 2.1 Шугам болон трансформаторын алдагдал төлөх кВт.ц /сард/ | | | 1145 |
| | 2.2 Урьдчилгаа төлбөр, мян, төг | | | |
| | 2.3 Эрчим хүчний төлбөр тооцоо хийх хугацаа<br>2.3.1. Сар бүрийн тоолуурын заалт авах өдөр<br>2.3.2. Төлбөрийн нэхэмжлэл банкинд очсон байх өдөр<br>2.3.3. Тухайн сарын төлбөрөө төлсөн байх сүүлийн өдөр<br>2.3.4. Алданги тооцох хувь<br>2.3.5. Алданги тооцож эхлэх өдөр<br>2.3.6. ЦЭХ-ний хэрэглээг түдгэлзүүлж эхлэх өдөр | | | 8-15<br>25-31<br>5-8<br>15<br>0,2%<br>16<br>17 |
| | 2.6 Хэрэглэгийн төлбөр төлөх банкны нэр, дансны дугаар | | | **44000500-5434195488** |
| | 2.7 Төлбөрийн мэдээлэл хүлээн авах гар утасны дугаар | | | **90116046** |

## ХАВСРАЛТ№2: ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМЖЭЭ /КВТ.Ц/

| Он | 1-р сар | 2-р сар | 3-р сар | улирлын дүн | 4-р сар | 5-р сар | 6-р сар | улирлын дүн | 7-р сар | 8-р сар | 9-р сар | улирлын дүн | 10-сар | 11-р сар | 12-р сар | улирлын дүн | Жилийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2026 | | | | | | | | | | | | | | | | | |
| 2027 | | | | | | | | | | | | | | | | | |
| 2028 | | | | | | | | | | | | | | | | | |

**Хангагчийг төлөөлж:**

УБТЗ ХНН Эрчим хүч ус хангамжийн 1-р анги

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн гэрээний техникч

Энхболд овогтой Чингэрэл

/ /гарын үсэг

**Хэрэглэгчийг төлөөлж :**

Глобал сивик шэйринг ТТ-ийн захирал:

Нарангэрэл овогтой Батдорж

/ /гарын үсэг

## ХАВСРАЛТ №3: ХАНГАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЭЗЭМШЛИЙН ЗААГ




**Эзэмшлийн зааг бичиглэлээр**: Партизан 35/10 кВ дэд станцын яч№6фидерээс гарсан 10кВ ЦДАШ-н тулгуур №413-аас кабель шугамын эхний холболтоор:

**Хангагчийг төлөөлж:**

УБТЗ ХНН Эрчим хүч ус хангамжийн 1-р анги

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн гэрээний техникч

Энхболд овогтой Чингэрэл

/ / гарын үсэг

**Хэрэглэгчийг төлөөлж :**

Глобал сивик шэйринг ТГ-ийн захирал:

Наранэрдэнэ овогтой Батдорж

/ гарын үсэг

## ХАВСРАЛТ №4: ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

20... он ..... сар .... өдөр № .....................хот/аймаг/

**Гэрээний биелэлтийн байдалд өгөх дүгнэлт**

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

**Шийдвэрлэсэн нь:**

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

**Гэрээ дүгнэсэн:**

**Хангагчийг төлөөлж:**

УБТЗ ХНН Эрчим хүч ус хангамжийн 1-р анги

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн гэрээний техникч

..................................овогтой.............................

/ / гарын үсэг

**Хэрэглэгчийг төлөөлж :**

..................................овогтой.............................

/ / гарын үсэг

Тайлбар (Хялгасан судал)

Global Civic Sharing

**“ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ” ТГ**
9093907 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, Жаргалант тосгон, Рашаант өртөө, Ухны ам 1-1
Утас: 90116046 99069283

2024.05.06 № 24/043
танай ________________ -ны № _____

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсье

Манай “Глобал Сивик Шэйринг” төлөөлөгчийн газраас орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй “Хүртээмжтэй мал аж ахуй” төслийн хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр “Роуд Дэвэлопмент” ХХК-тай байгуулсан барилга, угсралтын гэрээний дагуу “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төв”-ийн барилга угсралтын ажлыг дуусгаж байнгын ашиглалтад хүлээж авах ажил хийгдэж байна.

Тус барилгын дотор ханын хэсэг газар хялгасан судал үүссэн байгааг барилгын зургийн зохиогч “Уран үзэг” ХХК, барилга угсралтын гүйцэтгэгч “Роуд Дэвэлопмент” ХХК-иас тодруулсан ба энэ нь тухайн судал үүссэн хэсгийн шаврын ажлыг намар орой хийж гүйцэтгэсэн, хялгасан судлууд нь барилгын үндсэн хийцээс бус дотор заслын ажил гүйцэтгэлтэй холбоотой гэх тайлбарыг бидэнд өгсөн.

Барилгын ашиглагч болох манай “Глобал Сивик Шэйринг” төлөөлөгчийн газрын зүгээс тухайн хялгасан судлууд нь ашиглалт, өнгө үзэмжид төдийлөн нөлөөлөхүйц биш, барилгын үндсэн хийцээс хамааралгүй гэх тайлбарыг харгалзан үзэж ашиглалтад авахыг зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ: Н.БАТДОРЖ

"УРАН ҮЗЭГ" ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 4-р хороо,
Сөүлийн гудамж 49-16 Утас/Факс: (976) 89064595
uranuzeg@gmail.com

ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

2024 оны 04 сарын 26 өдөр

Тус компаний боловсруулсан зураг төслөөр Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд баригдсан. Хөдөө аж ахуйн сургалтын төвийн барилгын 2022-05-12 өдрөөс ЗХ-01/2022 дугаартай зохиогчийн хяналтын гэрээ байгуулж 2024-01-04 өдрийг хүртэл ажилсан болно.

Иймд барилгын явцад захиалгач байгууллагын хүсэлтээр сургалтын заалны буланд 1,2 давхарт тус бүр метал хийцлэлээр агуулахын өрөөг шийдсэн болно. Мөн угсралтын явцад захиалагч байгууллагын санхүүжилтэй холбоотойгоор намрын сэрүүнд, дотор шаврын ажил хийгдсэн нь зарим газарт хялгасан судлал үүссэн байна.

Тус хялгасан судлал нь барилгын үндсэн бат бөх хийцлэлтэй холбоогүй тул дотор заслын ажилаар шийдэх боломжтой гэж үзэж байна.

ЗАХИРАЛ Ө.ЭРДЭНЭГЭРЭЛ

ROAD DEVELOPMENT
**РОУД ДЭВЭЛОПМЕНТ ХХК**
УБД 9011370047, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
1 дүгээр хороо, 120 мянгат 10-р байр 2 тоот
Утас: 8811-4525, 976-7737-4525
И-мэйл: road2007b@gmail.com
Вэб: www.road.mn

2024.04.25 № 16/24
танай __________-ны № __________-т

ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх
тухай

Бид Глобал Сивик Шэйринг төлөөлөгчийн газартай 2022 оны 04 дүгээр сарын 27 ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Ухны ам, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилга угсралтын 2022/001 дугаартай ажлын гэрээг байгуулж тус ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 27 ны өдрөөс эхэлж 2023 оны 06 дугаар сарын 30 ны өдөр хүртэл барилга угсралтын ажлыг гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан.

Ингээд тус ажлын дотор заслын ажлыг гүйцэтгэх хугацаанд буюу тодруулбал дотор ханын хэсэг газрын шаврын ажлыг намар орой хийж гүйцэтгэн дуусгасантай холбоотойгоор хэсэг газар хялгасан судал үүссэн болно. Тус хялгасан судлууд нь барилгын үндсэн хийцээс бус дотор заслын ажлын учир шалтгаанаас үүдэлтэй хялгасан судлууд болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.БАТСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
РОУД ДЭВЭЛОПМЕНТ ХХК
9022050989
5185718 СБТ19006

Тайлбар (Ачуулсан)

Global Civic Sharing

**“ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ” ТГ**
9093907 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, Жаргалант тосгон, Рашаант өртөө, Ухны ам 1-1
Утас: 90116046 99069283

2024.05.06 № 24/044
танай ________________ -ны № _____

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсье

Манай “Глобал Сивик Шэйринг” төлөөлөгчийн газраас орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй “Хүртээмжтэй мал аж ахуй” төслийн хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр “Роуд Дэвэлопмент” ХХК-тай байгуулсан барилга, угсралтын гэрээний дагуу “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төв”-ийн барилга угсралтын ажлыг дуусгаж байнгын ашиглалтад хүлээж авах ажил хийгдэж байна.

Тус барилгын 1, 2 дугаар давхарт агуулах төлөвлөөгүй байсныг барилга угсралтын явцад захиалагч байгууллага болох манай “Глобал Сивик Шэйринг” төлөөлөгчийн газрын хүсэлтийн дагуу сургалтын заалны арын хэсэгт хонгил үүсгэсэн байгаа ба тус хонгилын 1-р давхарын таазыг төмөр рам зангидаж, ашиглалт, даацын аюулгүй байдлыг хангасан зузаан модон шалаар хучиж 2-р давхарт шал үүсгэн агуулахаар ашиглахаар төлөвлөж байгаа болно.

ЗАХИРАЛ: Н.БАТДОРЖ

ГЛОБАЛ СИВИК ШЭЙРИНГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ТӨВТЭЙ УЛСАД САЛБАР • БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС • Global Civic Sharing 9024020110 9093907 УЛААНБААТАР ХОТ

ROAD DEVELOPMENT

**РОУД ДЭВЭЛОПМЕНТ ХХК**
УБД 9011370047, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
1 дүгээр хороо, 120 мянгат 10-р байр 2 тоот
Утас: 8811-4525, 976-7737-4525
И-мэйл: road2007b@gmail.com
Вэб: www.road.mn

2024.04.26 № 172/24
танай __________-ны № __________-т

# ТОДОРХОЙЛОЛТ

Тайлбар хүргүүлэх
тухай

Бид Глобал Сивик Шэйринг төлөөлөгчийн газартай 2022 оны 04 дүгээр сарын 27 ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Ухны ам, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сургалтын төвийн барилга угсралтын 2022/001 дугаартай ажлын гэрээг байгуулж тус ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 27 ны өдрөөс эхлэж 2023 оны 06 дугаар сарын 30 ны өдөр хүртэл барилга угсралтын ажлыг гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан.

Ингээд тус барилгын захиалагч, ашиглагч байгууллага болох Глобал Сивик шэйринг төлөөлөгчийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу дараах өөрчлөлтийг хийх болсон.

Үүнд: Барилгын хурлын заалны хажуугийн 1, 2-р давхарт агуулахын өрөө хийх зорилгоор хонгил үүсгэсэн ба 1-р давхрын таазыг битүүлж, 2-р давхарт шал үүсгэн агуулахын зорилгоор ашиглах хүсэлтэй байгаагаа ирүүлсэн болно.

УЛААНБААТАР ХОТ
РОУД ДЭВЭЛОП...
ХХК
9022050989
5185718 СБТ19006

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.БАТСАЙХАН

"УРАН ҮЗЭГ" ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 4-р хороо,
Сөүлийн гудамж 49-16 Утас/Факс: (976) 89064595
uranuzeg@gmail.com

ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

2024 оны 04 сарын 27 өдөр

Тус компаний боловсруулсан зураг төслөөр Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд баригдсан. Хөдөө аж ахуйн сургалтын төвийн барилгын 2022-05-12 өдрөөс ЗХ-01/2022 дугаартай зохиогчийн хяналтын гэрээ байгуулж 2024-01-04 өдрийг хүртэл ажилсан болно.

Иймд барилгын явцад захиалгач байгууллагын хүсэлтээр сургалтын заалны буланд Ү3-Х3 тэнхлэгийн дагуу агуулах шийдэж өгөх хүсэлтийн дагуу 1,2 давхрын холбосон төмөр метал хийцлэлээр тус тус давхарт нь агуулахын өрөөг шийдсэн болно.

ЗАХИРАЛ Ө.ЭРДЭНЭГЭРЭЛ